



Монгол Улсын Засгийн газар



Нэгдсэн Үндэстний Байгууллага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Тусламжийн Хүрээ

2012-2016

Улаанбаатар, Монгол улс
2011 он

Гарын үсэг

Үндэсний хөгжлийн цогц бодлого, Мянганы хөгжлийн зорилтуудад тусгагдсан тэргүүлэх чиглэлийг дэмжих зорилго бүхий НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээний зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, уялдаа, түншлэлийг хангаж ажиллахаар Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын системийн байгууллагууд харилцан тохиролцов.



Гомбожавын Занданшатар
Монгол Улсын Их Хурлын гишүүн,
Гадаад Харилцааны Сайд



Сезин Сииваноглу
НҮБ-ын Суурин Зохицуулагч,
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Суурин Төлөөлөгч



Рана Флауверс
НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин Төлөөлөгч



Аржентина Матавел Пиккин
НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин Төлөөлөгч



Др. Виват Рожанапитаякорн
ДЭМБ-ын Суурин Төлөөлөгч




Викториа Секитолемо
Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын Суурин Төлөөлөгч



Анн Херберт
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Захирал



Абхиманью Синг
НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын
төрөлжсөн Байгууллагын Захирал ба Суурин Төлөөлөгч



Эден Пинтор-Гарде
НҮБ-Хабитат Хөтөлбөрийн үүрэг гүйцэтгэгч,
Техникийн ерөнхий зөвлөх




Стивен Краус
НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн Хөтөлбөрийн Ази, Номхон
Далайн бүсийн дэмжих багийн Захирал



Жүзеппе де Винченцийс
НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхлэх дээд комиссарын
газрын БНХАУ, Монгол улсыг хариуцсан
бүсийн Төлөөлөгч




Флавина Панснерн
НҮБ-ын Сайн Дурын Байгууллагын
Гүйцэтгэх Зохицуулагч



Юнг-Ву Парк
НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Ази, Номхон
Далайн бүсийн Захирал



Эдвард Кларенс-Смит
НҮБ-ын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Байгууллагын
Бээжин дэх Төлөөлөгч



Дазу Яанг
Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн Ази, Номхон Далайн хэлтсийн
Техник хамтын ажиллагааны газрын Захирал

Агуулга

Гарын үсэг	i
Агуулга	ii
Товч агуулга	iii
Монгол Улсын газрын зураг	iv
НҮБын Хөгжлийн тусламжийн х үрээ.....	1
1. Оршил.....	2
1.1 НҮБХТХний зорилго.....	2
1.2 2007-2011 онд хэрэгжсэн НҮБХТХний сургамж	2
1.3 НҮБын харьцангуй давуу талууд.....	3
1.4 Улс орны нөхцөл байдал ба хэтийн төлөв.....	4
2.0 НҮБын Хөгжлийн тусламжийн хүрээний үр дүнгүүд.....	5
2.1 Тэргүүлэх чиглэлүүд ба хэрэгжүүлэх стратеги	5
Салбар дамнасан асуудлууд.....	6
2.2 Үр дүн.....	7
Тэргүүлэх чиглэл 1: Эдийн засгийн тогтвортой хөгжил.....	8
Тэргүүлэх чиглэл 2: Нийгмийн суурь үйлчилгээ ба нийгмийн хамгаалал.....	10
Тэргүүлэх чиглэл 3: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдлийг бууруулах	15
Тэргүүлэх чиглэл 4: Засаглал ба хүний эрх	18
3.0. НҮБын Хөгжлийн тусламжийн х үрээнээс гадуур хэрэгжүүлэх үйл ажиллагаа.....	22
4.0 Шаардагдах санхүүжилт.....	23
5.0 Хэрэгжилт	24
6.0 Хяналт шинжилгээ, үнэлгээ	25
Үрдүнгийн х үснэгт.....	26
Хавсралт А: МХЗ-уудын хэрэгжилт	62
Товчилсон нэрс.....	74

Товч агуулга

НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ) нь Монгол Улсын Засгийн газар ба Нэгдсэн үндэстний байгууллага хоорондын 2012-2016 оны хамтын ажиллагааны стратегийн чиглэл, үлээгдэх үр дүнг тодорхойлсон баримт бичиг юм. НҮБХТХ -д Монгол улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг хангахад НҮБ-ын зүгээс үзүүлэх тусламжийг тодорхойлон, Монгол улсын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд гарч буй өөрчлөлт ийн талаарх дүгнэлтийг тусгав. Энэхүү баримт бичгийг МБ -аас одоо хэрэгжүүлж буй Хөгжлийн тусламжийн хүрээний төсөл, хөтөлбөрөөс олж авсан туршлага сургамж, НҮБ-ын байгууллагуудын харьцангуй давуу талын үнэлгээнд үндэслэн засгийн газар, иргэний нийгэмтэй хамтран боловсруулсан болно. Энэ нь мөн Нэгдсэн үндэстний байгууллага Монгол улсад үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах үндэслэлийг тодорхойлсон баримт бичиг юм.

Нэгдсэн үндэстний байгууллага нь энэхүү Хөгжлийн тусламжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэмд хөгжлийн бусад түнш үүдтэй стратегийн дөрвөн үндсэн чиглэлээр хамтран ажиллана:

- 1. Эдийн засгийн хөгжилд оролцоо, тэгш байдлыг хангаснаар ядуурлыг бууруулахад нөлөөлөх**
- 2. Нийгмийн суурь үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой систем бий болгох**
- 3. Байгалийн нөөцийн удирдлагын тогтвортой байдал, экологийн тогтолцоо болон хүн амын эмзэг давхаргын уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан дасан зохицох чадварыг сайжруулах**
- 4. Хүний эрхийг хамгаалах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор засаглалыг сайжруулах**

НҮБ нь дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд **13 үр дүнд** хүрэхэд бодитой хувь нэмэр оруулахад техникийн дэмжлэг үзүүлэх, нөөц эх үүсвэрийг дайчла х, нөлөөллийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах болно. Үр дүнгүүд нь үндэсний хөгжлийн болон МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай институцийн ба зан үйлийн өөрчлөлтийг хамарч байгаа юм. Эдгээр үр дүнг хэрэгжүүлэх хариуцлагыг Монгол Улсын Засгийн газар болон ҮН хамтран хүлээнэ. НҮБ-ын байгууллага бүр эрхэлсэн асуудлынхаа үрээнд батлагдсан хөтөлбөр, төслүүдээрээ дамжуулан холбогдох үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулах болно.

НҮБХТХ-нд тэргүүлэх чиглэл, үр дүн, шаардагдах эх үүсвэр, хэрэгжүүлэх үйл явц, механизм, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон НҮБХТХ -ээс гадуур хэрэгжүүлэх санал санаачлагуудыг тусгасан болно. Үр дүн, зорилт, шалгуур үзүүлэлт, төсвийн эх үүсвэрийн талаар дэлгэрэн мэдээллийг **Үр дүнгийн хүснэгтэд** хавсаргав.

Монгол Улсын газрын зураг



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Тусламжийн Хүрээ, 2012- 2016

	Үзүүлэлтүүд	Тоо	Тайлбар	Он	Эх сурвалж
Хүн ам	Хүн ам	2,735,8	1000 хүн	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн ам /хүйсээр/	51.1	%, эмэгтэй	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн ам /байршил/	37.4	%, хөдөө орон нутагт	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн ам (15-аас доош нас)	27.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн ам (15-64 нас)	68.3	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн ам (64-с дээш насны)	4.1	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Төрөлтийн нийлбэр коэффициент	2.7	нэг эмэгтэйд ногдох	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Хүн амын өсөлтийн хувь	1.9	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Эдийн засаг	Дотоодын нийт бүтээгдэхүүн	6,055.8*	тэр бум төгрөг, оны	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Дотоодын нийт бүтээгдэхүүн	4,203.1*	сая. ам.доллар, оны	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Нэг хүнд ногдох ДНБ / мян.төг /	2,234.5*	мян. төг, оны үнээр	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Нэг хүнд оногдох ДНБ /ам.доллар/	1,550.9*	ам.доллар, оны үнээр	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	ДНБ-ний өсөлт	1.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ажилгүйдлийн түвшин	11.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ажилгүйдлийн түвшин /хүйсээр/	11.5	%, эмэгтэй	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ажиллах хүчний оролцооны түвшин/хувиар/	66.8	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ажиллах хүчний оролцооны түвшин /хүйсээр/	61.8	%, эмэгтэй	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Инфляцийн түвшин	8.0	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Үйлдвэрлэлийн нийт гарц	1,763.3	тэр бум. төг, 2005 оны	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Цалингийн дундаж хэмжээ	300.5	мян. төг сард	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	ДНБ-д Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь	43.1	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Экспортод Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний эзлэх хувь	4.5*	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	754.9	MNT billions	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Импорт	2,137.7	сая ам.доллар	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Экспорт	1,885.4	сая ам.доллар	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Гадаад худалдааны баланс	-252.3	сая ам.доллар	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Албан ёсны цэвэр нөөц	1,145.3	сая ам.доллар	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Ядуурал	Ядуурлын хамралтын хүрээ	38.7	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын хамралтын хүрээ байршлаар (хот)	30.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын хамралтын хүрээ байршлаар (хөдөө)	49.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын гүнзгийрэлт	10.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Тусламжийн Хүрээ, 2012- 2016

	Ядуурлын гүнзгийрэлт байршлаар (хот)	7.9	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын гүнзгийрэлт байршлаар (хөдөө)	14.4	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын мэдрэмж	4.1	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын мэдрэмж байршлаар (хот)	2.9	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Ядуурлын мэдрэмж байршлаар (хөдөө)	5.6	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Эрүүл мэнд	Дундаж наслалт (эрэгтэй)	64.3	Жил	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Дундаж наслалт (эмэгтэй)	71.8	Жил	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Нялхсын эндэгдлийн түвшин	24.3	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын	2009	www.childmortality.org, Inter-Agency Group on Mortality Estimates
	5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	28.8	1,000 амьд төрөлтөд ногдох	2009	www.childmortality.org, Inter-Agency Group on Mortality Estimates
	Эхийн эндэгдлийн түвшин	81.4	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Жин багатай дутуу төрсөн хүүхдийн хувь	4.2	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Хүүхдийн дархлаажуулалтад хамралтын коэффициент төрлөөр /БЦЖ/	98.8	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Дархлаажуулалт хамрагдсан хүүхдийн хувь /Polio/	97.1	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Дархлаажуулалт хамрагдсан хүүхдийн хувь //DPT/	96.0	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь /Улаан бурхан/	96.5	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь /Гепатит В/	98.8	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь /Халдварт саа/	97.4	%	2009	Эрүүл мэндийн үзүүлэлт, 2009, ЭМЯ
	ХДХВ-ийн тархалтын түвшин	< 0.02	%	2008-2009	UNGASS 2010 Country Progress Report
	Баталгаат ундны усны хангамжтай хүн амын эзлэх хувь	54.5	%	2007-2008	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008, УСХ
	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдсан хүн амын эзлэх хувь	43.1	%	2007-2008	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008, УСХ
Боловсрол	Бага боловсролын хамран сургалтын бохир жин	99.2	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Дунд боловсролын хамран сургалтын бохир жин	93.2	%	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Амьдралын хэв маяг	Интернэт байнгын хэрэглэгчдийн тоо	39	1,000 хүн тутамд	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо	815	1,000 хүн тутамд	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Дэд бүтэц	Төмөр замын нийт урт	1,815	км	2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
Хүний хөгжил	Хүний хөгжлийн индекс	0.742*		2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	Жендэрийн хөгжлийн индекс	0.741*		2009	Статистикийн эмхтгэл, 2009 он
	УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь	3.9	%	2008	Статистикийн эмхтгэл, 2008 он

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл

НҮБ-ын Хөгжлийн тусламжийн үрээ

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД	Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааг сайжруулах замаар МХЗ-уудыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулах	Боловсролыг хөгжүүлэх, бүх нийтэд эрүүл мэндийн үр нөлөөтэй үйлчилгээг хүргэх, нийгмийн хамгаалал, халамжийн шинэтгэл хийх	Хүрээлэн байгаа орчин болон уур амьсгалын өөрчлөлтөд илүү сайн дасан зохицох, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах чадавхийг хөгжүүлэх	Засгийн газрын хариуцлага, ил тод байдал, хүний эрхийг хамгаалж, жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэх чадавхийг дээшлүүлэх
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД	МХЗ 1 – Ядуурал, өлсгөлөнг бууруулах	МХЗ 2 – Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших МХЗ 4 – Хүүхдийн эндэгдлийг бууруулах МХЗ 5 – Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах МХЗ 6 – БЗДХ, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	МХЗ 7 – Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	МХЗ 3 – Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх МХЗ 8 - Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх МХЗ 9 - Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх
НҮБХТХ-НИЙ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	Эдийн засгийн тогтвортой хөгжил Эдийн засгийн хөгжилд оролцоо, тэгш байдлыг хангаснаар ядуурлыг бууруулахад нөлөөлөх	Нийгмийн суурь үйлчилгээ ба нийгмийн хамгаалал Нийгмийн суурь үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой систем бий болгох	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдлийг бууруулах Байгалийн нөөцийн удирдлагын тогтвортой байдал, экологийн тогтолцоо болон хүн амын эмзэг давхаргын уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан дасан зохицох чадварыг сайжруулах	Засаглал ба хүний эрх Хүний эрхийг хамгаалах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор засаглалыг сайжруулах
ҮР ДҮН	ҮР ДҮН 1. Ядуу болон эмзэг бүлгийн хүн амын амьжиргааны нөхцөл сайжирсан байна	ҮР ДҮН 3. Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн боловсролын чанар ба хүртээмж сайжирсан байна	ҮР ДҮН 7. Үндэсний болон орон нутгийн түвшинд байгалийн нөөц баялгийг анхан шатны хэрэглэгчдийн оролцоог хангаж, тогтвортой ашиглах салбарын чадавхи бүрэлдсэн байна	ҮР ДҮН 10. Төв ба орон нутгийн засаг захиргааны түвшинд нотолгоонд суурилсан төлөвлөгөө, төсөв боловсруулах, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи дээшилсэн байна
	ҮР ДҮН 2. Ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, стратегийг боловсруулсан байна	ҮР ДҮН 4. Хотын гэр хороолол болон өдөө орон нутгийн хүн амын найдвартай ус хангамж, ариун цэврийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангасан байна	ҮР ДҮН 8. Үндэсний болон орон нутгийн түвшинд байгалийн ба хүний хүчин зүйлээс шалтгаалсан гамшгийн эрсдэл, үр дагаварыг бууруулсан байна	ҮР ДҮН 11. Засаглалын байгууллагуудын төлөөлөл, хариуцлага, ил тод байдал дээшилсэн байна
		ҮР ДҮН 5. Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмж болон ашиглалт нэмэгдсэн байна	ҮР ДҮН 9. Эрчим хүчний үр ашгийг сайжруулах, ногоон өсөлтийг хангаж, хотын агаарын бохирдлыг бууруулах шинэ технологи нэвтрүүлсэн байна	ҮР ДҮН 12. Хүний эрхийг дэмжиж, хамгаалах үндэсний тогтолцоо сайжирсан байна
		ҮР ДҮН 6. Эмзэг бүлгийнхэнд онцгой анхааран нийгмийн хамгаалал бэхжиж, өргөжсөн байна		ҮР ДҮН 13. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, жендэрийн асуудлыг бодлого, хөтөлбөрт тусгах чадавхи сайжирсан байна

1. Оршил

1.1 НҮБХТХ-ний зорилго

НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ) нь Монгол Улсын Засгийн газар, Монголд үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын системийн байгууллагууд хоорондын 2012-2016 оны хамтын ажиллагааны стратегийн чиглэл, хүлээгдэх үр дүнг тодорхойлсон баримт бичиг юм. Энэхүү НҮБХТХ-нд Монгол Улсын 2008-2021 оны Үндэсний хөгжлийн цогц бодлого, 2015 он гэхэд Мянган хөгжлийн зорилтуудыг хангах, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд НҮБ -ын системийн байгууллагуудаас хамтран авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнчлэн, Монгол улсын эдийн засаг, нийгэм болон хүрээлэн байгаа орчинд гарч буй өөрчлөлтийн талаарх дүгнэлтийг тусгав.

НҮБХТХ нь НҮБ-ын хуримтлуулсан туршлага, сургамжид үндэслэн НҮБ -аас Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулах үндэслэлийг тодорхойлсон баримт бичиг юм. НҮБХТХ-нд Монгол Улсын хөгжлийн асуудлыг бүхэлд нь авч үзэж байгаа ч, боловсрол, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, эдийн засгийн өсөлт, засаглал, олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтэд тогтвортой амжилт гаргах зорилгоор зарим салбар, бүс нутаг, зорилтот бүлгүүдэд онцгой анхаарал хандуулсан болно.

НҮБХТХ-г Монгол Улсын Засгийн газартай өргөн хүрээнд хэлэлцэн зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулсан бөгөөд үүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Гадаад харилцааны яам, салбарын яамд болон холбогдох газрууд идэвхитэй оролцсон болно. Энэхүү баримт бичгийг боловсруулахад 2010 оны 4-дүгээр сард хийгдсэн Улс орны нийтлэгүнэлгээнд тусгасан хөгжлийн үзүүлэлтүүд, судалгаа шинжилгээ, бусад мэдээллийг ашиглав. Үндэсний хөгжлийн бодлого болон улс орны нийтлэг үнэлгээг удирдамж болгон Засгийн газар ба НҮБ -ын хамтарсан тэргүүлэх чиглэлүүдийг дөрвөн үндсэн салбараар тодорхойлж, холбогдох ажлын хэсгүүдийг байгуулан ажилласан болно. Эдгээр ажлын хэсэгт НҮБ-ын системийн үйл байгууллага, засгийн газрын болон төрийн бус, хөгжлийн бусад түнш, олон улсын санхүүгийн байгууллагууд, хоёр талт хандивлагчийн төлөөлөгчид оролцов.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын Бээжин, Бангкок дах салбарын төлөөлөгчид ажлын хэсгүүдэд гишүүнээр ажиллах, НҮБ-ын Монгол Улс дахь багийн уулзалт зөвлөгөөнд оролцох замаар хамрагдсан бөгөөд тэдний хувь нэмэр энэхүү баримт бичигт тусгагдсан болно. Улс орны нийтлэг үнэлгээ болон НҮБХТХ нь НҮБ-ын системийн байгууллагуудаас 2012-2016 онд Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах удирдамж болно.

1.2 2007-2011 онд хэрэгжсэн НҮБХТХ-ний сургамж

2007-2011 оны НҮБХТХ-ний дунд хугацааны үнэлгээнээс (2009 оны 6-р сард хийгдсэн) дараагийн шатанд хэрэгжүүлэх стратегийн 6 зөвлөмж гаргасан нь:

- а. МХЗ-ууд, ялангуяа ахиц дэвшил удаашралтай байгаа зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн бодлого, төсөв боловсруулах чадавхийг дээшлүүлэх.

б. Монгол Улсын Мянганы хөгжлийн ес дэх зорилтын хүрээнд хүний эрх, жендэрийн тэгш байдал, засаглалтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэлийг бэхжүүлэхэд техник туслалцаа үзүүлэх.

в. Орон нутгийн үвшинд нийгмийн үйлчилгээг (эрүүл мэнд, ус хангамж, эрүүл ахуй, хөдөлмөр эрхлэлт) сайжруулахад цогц уялдаа бүхий дэмжлэг үзүүлэхийн тулд НҮБ-ын дэмжлэгийг шаардлагатай бүс нутгууд руу төвлөрүүлэх, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийн оролцоог хангах.

г. Цаг уурын өөрчлөлт, цөлжилт, гамшгийн эрсдлийг бууруулах, дасан зохицох асуудлыг шийдвэрлэх.

д. Уул уурхайн салбар өргөжиж байгаатай холбогдон үүсч буй асуудлууд, тухайлбал байгаль орчинд үзүүлэх нөлөө, орон нутгийн засаглал, нийгмийн бусад асуудлуудыг шийдвэрлэх.

е. Дэлхийн эдийн засгийн хямралын сөрөг нөлөөг бууруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, ялангуяа хүн амын эмзэг хэсэгт онцгой анхаарал хандуулах.

1.3 НҮБ-ын харьцангуй давуу талууд

Үндэсний хөгжлийн цогц бодлого, МХЗ-уудын хэрэгжилт нь эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, түүний үр шимийг тэгш хүртээх зохицуулалтын арга хэмжээнээс хамаарна. Уул уурхай, эдийн засгийн өсөлтөөс бий болох орлогыг үндэс ний тэрүүлэх чиглэлийн болон хэрэгжилт нь удаашралтай байгаа МХЗ-уудыг эрчимжүүлэхэд чиглүүлэхэд улс төрийн үүрэг амлалт, шийдэмгий алхам шаардлагатай.

Монгол улсын үүхэн шилжилтийн энэ үед дээрх хүчин чармайлтыг хэрэгжүүлэхэд НҮБ бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байна. ИБ нь өөрийн эх үүсвэр, мэдлэгийн бааз суурь, дэлхий нийтийг хамарсан үзлэгээ ашиглан засгийн газрын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нийгмийн эмзэг бүлгүүдэд түлхүү чиглүүлэх, тэднийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллах болно.

НҮБ-ын харьцангуй давуу талууд нь:

- а. Монгол Улсын Засгийн газартай урт хугацааны хамтын ажиллагааны түүхтэй;
- б. НҮБ-ын дэмжлэгтэйгээр батлагдсан олон улсын конвенци, хэм хэмжээ, стандартыг мөрдүүлэх ажлыг хөхиүлэн дэмжиж ирсэн, хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагыг чиг баримжаа болгодог;
- в. Олон талуудыг татан оролцуулж, хандивлагчдын уялдаа холбоо, зохицуулалтыг үндэсний хэмжээнд ханган хэрэгжүүлэх боломжтой;
- г. Үндэсний манлайллыг дэмжих хүрээнд бүх түвшинд чадавхи бэхжүүлэхийг чухалчилдаг;

- д. Техник арга зүйн мэдлэг болон олон улсын туршлагад үндэслэн бодлогын зөвлөгөө өгөхдөө төвийг сахисан, шударга байр суурь баримталдаг зэрэг болно.

1.4 Улс орны нөхцөл байдал ба хэтийн төлөв

Монгол орон уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийн үр дүнд эрчимтэй өөрчлөлтийн үед ороод байна. ДНБ 2006-2008 онд жилд дунджаар 9.2 хувиар өссөн бөгөөд энэ хугацаанд дэлхийн эдийн засгийн дундаж өсөлт 4.3 хувь байсан юм. ДНБ 2010 онд 8.5 хувь¹ 2011 онд 7,5 хувиар өсөх төлөвтэй байгаа ба 2008 онд уул уурхай ДНБ-ий 22.5%, нийт экспортын 60%-ийг үйлдвэрлэсэн байна. Оюу Толгойн алт, зэсийн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд 2009 оны 10-р сард гарын үсэг зурснаар ашигт малтмалын салбарын эдийн засагт эзлэх хувь улам нэмэгдэх бөгөөд Монгол улс эдийн засаг нь уул уурхайгаас хамааралтай орнуудын нэг болж байна.² Энэ нь Монголын эдийн засаг олон улсын санхүүгийн хямрал болон түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамааралтай болж байна гэсэн үг юм.

Дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал болон түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалж ДНБ 2009 онд огцом буурчээ. Мөн 2009-2010 оны зуд эдийн засаг, инфляц, хүнсний аюулгүй байдалд хатуу сорилт болсон билээ. Түүхий эдийн үнэ өссөн, уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдсэний үр дүнд Монгол улсын эдийн засаг түргэн сэргэсэн бөгөөд Азид хамгийн эрчимтэй өсч буй эдийн засаг бүхий орнуудын нэг болоод байна.

Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, эдийн засаг өссөн хэдий ч ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, ажлын байр бий болгох, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр дорвитой ахиц гараагүй байна. МХЗ-уудын хэрэгжилтэд хийсэн үнэлгээнээс (*Хавсралт А*) үзэхэд МХЗ-уудын 66 хувийг 2015 он гэхэд хэрэгжүүлэх боломжтой байна. Гэвч Ядуурлыг бууруулах, Жендэрийн тэгш байдлыг хангах, Хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хангах, Ардчилсан засаглал ба хүний эрхийн талаарх дөрвөн зорилтыг 2015 он гэхэд хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй дүр зураг харагдаж байна.

Бусад зорилтын хэрэгжилтийн түвшин үндэсний хэмжээнд харилцан адилгүй, тодорхой бүс нутгуудад биелэгдэх боломж багатай байна. Үндэсний түвшинд сургуульд хамрагдалт, эх болон хүүхдийн эндэгдлийг бууруулахад ерөнхийдөө ахиц гарсан боловч мэдээллийг задлан ангилбал, хот, хөдөө, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, ядуу болон эмзэг бүлгийн дунд илэрхий ялгаатай байдал харагдаж байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газар ба ҮН-ын хөгжлийн төлөөх хамтын ажиллагаанд гол тулгамдсан асуудал болж байна.

¹ ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын мэдээ, 2010 оны 10-р сар

² Хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий 21%-ийг үйлдвэрлэдэг бөгөөд үндэсний ажиллах хүчний 38% энэ салбарт ажиллаж байна. Гэхдээ энэ салбар нь олон улсад үлэн зөвшөөрөгдсөн стандартуудыг хангаагүй, дайвар бүтээгдэхүүний бодитой үйлдвэрлэл хөгжөөгүй бөгөөд цаг уурын өөрчлөлт болон байгалийн гамшигт туйлын эмзэг өртөмтгий байна. 2009-2010 оны өвлийн зуданд нийт 9.7 сая мал хорогдсон нь хөдөө аж ахуйн салбар болон малчдын амьжиргаанд үлэмж сөрөг нөлөө үзүүлсэн юм. Үүний уршгаар улам олон тооны хүн амьдралын боломж хайн хот суурин газар руу шилжин суурьших болжээ.

Өнөөдөр түүхийн чухал үед тулж ирээд байна. Өсөн нэмэгдэж байгаа баялгийг зохистой удирдаж³ чадвал ядуурлыг бууруулах, чанартай боловсрол, үрл мэнд, ус хангамж, эрүүл ахуйн болон нийгмийн бусад үйлчилгээг иргэн бүрт тэгш хүртээх боломжтой болох юм.

Монгол улс хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор үрсхүчлийн хийн хэрэглээ багатай эдийн засгийг бэхжүүлэх талаар олон улсад үлгэр дуурайлал үзүүлэх боломжтой юм. Хүн ам зүйн хувьд Монгол улс таатай нөхцөлд байгаа бөгөөд ирэх гучин жилд хөдөлмөр эрхлэх насны хүн амын тоо өсч, хөдөлмөр эрхлэлтийн бодлого болон мэргэжлийн сургалтын чиглэлээр чухал шилжилт хийгдэнэ. Монгол улс “баялгийн хараал”- аас урьдчилан сэргийлж, бүх иргэдийн хувьд тэгш шударга нийгмийг байгуулахын тулд эдгээр давуу талаа ашиглан эрх тэгш хөгжлийн⁴ урт хугацааны зорилтыг боловсруулжүүнийг хэрэгжүүлэхэд бүх хүчин чармайлтаа чиглүүлэх нь чухал шаардлагатай байна.

2.0 НҮБХТХ-ний үр дүнгүүд

2.1 Тэргүүлэх чиглэлүүд ба хэрэгжүүлэх стратеги

НҮБ-ын системийн байгууллагууд 2012-2016 онд Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, хөгжлийн бусад түнш тэй хамтран үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд болон МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулахаар ажиллах болно.

НҮБ нь дараах стратегийн 4 тэргүүлэх чиглэлээр ажиллах болно:

1. Эдийн засгийн хөгжилд оролцоо, тэгш байдлыг хангаснаар ядуурлыг бууруулахад нөлөөлөх
2. Нийгмийн суурь үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой систем бий болгох
3. Байгалийн нөөцийн удирдлагын тогтвортой байдал, экологийн тогтолцоо болон хүн амын эмзэг давхаргын уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан дасан зохицох чадварыг сайжруулах
4. Хүний эрхийг хамгаалах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор засаглалыг сайжруулах

³ Саяхан батлагдсан Санхүүгийн тогтвортой байдлын тухай хуульд өсөн нэмэгдэж буй орлогыг хэрхэн үр ашигтай, зохистой байдлаар удирдаж, тогтвортой бөгөөд эрх тэгш хөгжлийг хангах асуудлыг тусгасан байна. Монгол Улс 2010 оны 10-р сард Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дагаж мөрдөхөө зарласан бөгөөд энэ нь газрын тос, байгалийн хий болон уул уурхайн компаниудын төлсөн төлбөр болон засгийн газрын орлогыг хэвлэн нийтэлж, баталгаажуулах замаар олзворлох уурхайн сайн засаглалыг бэхжүүлэх санаачлага юм. Дэлгэрэнгүй мэдээллийг [EITI](http://eiti.org) (<http://eiti.org>) and [Mongolia's progress](http://resources.revenuewatch.org/en/official-document/eiti-report-mongolia) <http://resources.revenuewatch.org/en/official-document/eiti-report-mongolia> сайтаас үзнэ үү.

⁴ 2008-2021 оны МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн бодлогыг хянан үзэж төсвийн орлогын өсөлтийг тусган ядуурлыг бууруулах шинэ стратеги боловсруулах нь зүйтэй.

Эдгээр тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд дараах гурван түвшинд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

- 1) Үндэсний түвшинд бодлого боловсруулахад зөвлөмж өгөх;
- 2) Хөгжлийн зорилтуудын тогтвортой үр дүнг хангахын тулд хамтран ажиллагч түншүүд буюу байгууллага, хувь хүмүүсийн чадавхийг хөгжүүлэх;
- 3) Шинэ хандлага, технологи, аргачлалыг үндэсний хэмжээнд дэлгэрүүлэхийн тулд олон нийт, орон нутгийн түвшинд туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх.

НҮБХТХ-нд 2007-2011 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрөөс олж авсан туршлага сургамж, НҮБ-ын харьцангуй давуу талд түшиглэн хөгжлийн хамтын ажиллагаанд дараах бодлогыг баримтална:

- а. Хэрэгжилт нь хоцорч байгаа, эсвэл тогтвортой үр дүн бий болгоход хүндрэлтэй, мөн бүс нутгуудын хооронд ялгавартай, үндэсний дунджаас хоцорч байгаа МХЗ-дын хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулна.
- б. Хөтөлбөрийн бүх үйл ажиллагаа зорилтот бүлэг, ялангуяа нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн байна.⁵
- в. Жендэрийн тэгш байдлыг хангахад дорвитой ахиц гаргана.
- г. МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс илүү хариуцлагатай, ил тод үйл ажиллагааг хангахад чиглэсэн засаглалын чадавхийг бэхжүүлнэ.
- д. Хүний эрхийн олон улсын байгууллага, бусад механизмын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулна. Үүний тулд хүний эрхийг бэхжүүлж, хамгаалах хууль эрх зүйн болон бодлогын орчин, тогтолцоо, механизмд түлхүү анхаарна.
- е. Хөгжлийн ололт амжилт, үр дүнг удирдах институцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор үндэсний чадавхийг хөгжүүлэх⁶ асуудлыг хөтөлбөрийн үйл ажиллагааны гол цөм болгоно.
- ж. Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба ДНБ-ний эрчимтэй өсөлтийн улмаас шинэ салбаруудад техникийн туслалцаа шаардагдаж болно. НҮБ, Засгийн газартай хамтран Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагаа, төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх боломжийг гүнзгийрүүлэн судална.

Салбар дамнасан асуудлууд

- I. **Жендэрийн тэгш байдлыг хангах зорилт** нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын бүх төрөлжсөн байгууллагын тэргүүлэх чиглэл хэвээр байна. Засгийн газар болон иргэний нийгэмтэй хамтран Монголын эмэгтэйчүүдэд тулгарч буй ноцтой асуудлууд, тэр дундаа ажил эрхлэлт ба зохистой ажлын байрны тэгш бус хүртээмж, улс төр ба шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй

⁵ Эмзэг бүлгүүдэд: ядуус, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ажилгүй залуус, шилжин суурьшсан ажилчид, угсаатны цөөнх, ДОХ/ХДХВ –тэй хүмүүс, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орогнол хүсэгчид болон дүрвэгсэд багтана.

⁶ Үндэсний чадавхийг хөгжүүлнэ гэдэг нь хувь хүмүүс болон институциуд өөрсдийн хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлэх чадвар юм.

байгаа явдал, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргана. .

- II. НҮБ нь хүний эрхийн тогтолцоог бэхжүүлэх, олон улсын хүний эрхийн хяналтын механизмтай нягт хамтран ажиллах, бүх салбарын хөтөлбөрт **хүний эрхэд тулгуурласан хандлагыг** хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- III. Өртөмхий байдлыг бууруулж, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхийн тулд **уур амьсгалын өөрчлөлт ба гамшгийн эрсдлийг** бууруулах асуудлыг бүх түвшний хөтөлбөрт тусгана.
- IV. Хөтөлбөрийн бүх салбарт **иргэний нийгмийн үүрэг оролцоог** хэвшүүлж, хөгжил ба хүний эрхийн асуудлаар засгийн газартай яриа хэлцэл өрнүүлэх чадавхийг бэхжүүлэхэд байнгын хүчин чармайлт шаардлагатай. НҮБ нь албан ба албан бус зөвлөлдөх механизмыг бий болгох, хөгжлийн үйл ажиллагаанд иргэд ялангуяа хүүхэд, залуусыг өргөнөөр оролцуулахад дэмжлэг үзүүлнэ. Иргэний нийгмийн байгууллагуудын гишүүнчлэл нь ихэвчлэн сайн дурын шинжтэй байдаг. НҮБ нь **сайн дурын зарчмыг** бэхжүүлэх замаар хөгжил ба төрийн албанд иргэд хувь нэмрээ оруулахад нь дэмжлэг үзүүлнэ.
- V. Уламжлалт мэдээллийн хэрэгсэл (ТВ, радио, сонин хэвлэл) болон мэдээлэл холбооны шинэ технологийг (гар утас, интернэт, нийгмийн сүлжээ) ашиглан **мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг** сайжруулах замаар зан үйлийн өөрчлөлтийг дэмжиж, ил тод болон хариуцлагатай байдлыг сурталчилсанаар засаглалын чанарыг сайжруулах боломж бий. Хүн амын нягтрал багатай Монгол орны хувьд энэ нь нэн тохиромжтой арга барил юм.

2.2 Үр дүн

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ –ын байгууллагууд нь тэдгээрийн 4 чиглэлийн хүрээнд **13 үр дүнд** хүрэхэд техник арга зүйн дэмжлэг, нөөц эх үүсвэр дайчлах, нөлөөлөл явуулах зэрэгт хүчин чармайлтаа төвлөрүүлнэ. Эдгээр ньүндэсний хөгжлийн зорилтууд болон МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай институцийн ба зан үйлийн өөрчлөлтийг хамарч байгаа юм.

Эдгээр үр дүнг хэрэгжүүлэх хариуцлагыг Монгол Улсын Засгийн газар болонНҮБ хамтран хүлээн болно. НҮБ-ын байгууллага бүр эрхэлсэн асуудлынхаа хүрээнд батлагдсан хөтөлбөр, төслүүдээрээ дамжуулан холбогдох үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулах үүрэгтэй.

Тэргүүлэх чиглэл 1: Эдийн засгийн тогтвортой хөгжил

Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд НҮБ нь эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг сайжруулахад хувь нэмэр оруулах болно. Үүний тулд зохистой хөдөлмөрт суурилсан эдийн засгийн өсөлтийг хангах бодлого боловсруулж, ЖДҮ, бичил санхүү, мэргэжлийн боловсрол, сургалт болон бизнес эрхлэх сургалтыг туршилтын журмаар хэрэгжүүлнэ.

НҮБ нь орон нутгийн эдгээр санаачлагад үндэслэн, хөгжлийн бусад түншүүдтэй хамтран ажиллах замаар ядуурлыг бууруулах бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. НҮБ нь техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан тэгш бус байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн өсөлтийг ядуурлыг бууруулахад чиглүүлэх, түүнчлэн уул уурхайн орлогыг ажил эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, цэвэр ус, эрүүл ахуй болон ариун цэвэр зэрэг эмзэг бүлгийнхэнд тулгарч байгаа нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү тэргүүлэх чиглэлийг дэвшүүлж байгаа гол үндэслэл нь алслагдсан орон нутгийн болон эмзэг бүлгийн дунд ажилгүйдэл, ядуурлын түвшин, зэрэг нь буурахгүй байгаатай холбоотой юм. Улс орны нийтлэг үнэлгээнд⁷ ядуусын ажиллаж буй хөдөө аж ахуй, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн бүтээмж бага, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал хангалтгүй, ядуурлыг бууруулах зорилго бүхий эдийн засгийн өсөлтийн бодлого дутагдаж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Иймээс уул уурхайгаас олох орлогыг ядуурлыг бууруулахад чиглүүлэх хүчин чармайлтыг нэмэгдүүлж түүнд зарцуулж буй өсвийн орлогын талаар илүү найдвартай мэдээллийг бүрдүүлэх, халамжаас цалин руу шилжих үзэл баримтлалыг тусгасан дунд ба урт хугацааны нийгмийн хамгааллын цогц бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Эдгээр тэргүүлэх чиглэлийн үр дүн нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна:

- МХЗ 1-ийг онцлон харгалзаж (зорилго 1, 3) хөгжлийн талаарх МХЗ-уудыг хэрэгжүүлэх (тэргүүлэх чиглэл 1)
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах (4.1)
- Шинжлэх ухаан ба технологи (4.7)
- Хөдөө аж ахуй ба хүнсний үйлвэрлэл (5.2.14)

Тэргүүлэх чиглэл 1 –ийн хүрээнд дараах 2 үр дүнг дэвшүүлж байна.

Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБ-ын ХХ	981,850	1,500,000
ОУХБ	170,000	250,000
НҮБ-ын ХХААБ	2,000,000	3,000,000
ОУХБ	-	230,000
НҮБ-Хабитат	50,000	100,000
НҮБ-ын ХС	130,000	520,000
НҮБ-ын БСШУБ	50,000	100,000
НИЙТ	3,381,850	5,700,000

⁷ Монгол дахь НҮБ: Улс орны нийтлэг үнэлгээ, 2012-2016 (2010 оны 4-р сар)

ҮРДҮН1. Ядуу болон эмзэг бүлгийн хүн амын амьжиргааны нөхцөл сайжирсан байна

НҮБ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн эдийн засгийн өсөлтийн стратегийг дэмжих, тухайлбал, ЖДҮ, бичил санхүү, мэргэжлийн болон бизнес эрхлэх сургалтыг сайжруулах замаар нийгмийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлнэ.

- Эдийн засаг ба хүрээлэн байгаа орчны хүчин зүйлсийн сөрөг нөлөөнд өртсөн малчид, хотод шилжин суурьшигчид, ядуу, эмзэг бүлгийн хүмүүст зориулсан амьжиргааны шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор албан бус салбарын талаар судалгаа явуулах.
- Одоогийн болон ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд чиглэсэн мэргэжлийн ба бизнес эрхлэх чадавхийг бий болгох, шинэ технологи болон аргачлалуудыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн бүтээмж ба маркетингийг сайжруулах.
- Хүн амын хамгийн эмзэг давхаргын хүнсний баталгаат байдал ба хоол тэжээлийн хангамжийг сайжруулахын тулд хүнс, хөдөө аж ахуйн салбар болон жижиг хэмжээний хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих. Үүнд ажилгүй болон өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд, хүнсний баталгаа муутай өрхүүдэд онцгой анхаарал тавина.

Хамтран оролцогч талууд :

Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НЗДТГ, Мэргэжлийн боловсрол, сургалтын агентлаг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яам болон холбогдох бусад яамд.

Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар Зохицуулах хороо байгуулах, эсвэл НҮБ -ын салбар агентлагууд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж болно.

ҮР ДҮН 2. Ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, стратегийг боловсруулсан байна

Монгол Улс уул уурхайн салбараас олох баялгийг хүн амын ядуу хэсэгт бодитой ашиг тустай зүйлсэд зарцуулахад дэмжлэг болох ядуурлыг бууруулах цогц бодлого боловсруулах үүрэг амлалт авсан билээ. Энэ бодлогоор дамжуулж нэг талаар нийгмийн халамж хамгаалал, нөгөө талаар зохистой хөдөлмөр эрхлэлт болон ур чадварыг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

НҮБ нь МХЗ 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үндэсний чадавхийг бэхжүүлэхэд голлон анхаарна. Үүнд:

- НҮБ нь ядуурлын зураглалыг гаргаж, тэгш бус байдлыг бууруулахад анхаарна. Улсын төсвийн үйл явц нь оролцоог хангасан, ядуурлыг бууруулахад чиглэсэн, хүүхдийн эрх ашгийг тусгасан байхад шаардлагатай механизмыг бүрдүүлэх, нийгмийн хамгааллын бодлого, тогтолцоог сайжруулахад чиглэсэн хөтөлбөрүүдэд шаардлагатай хөрөнгө төсөвлөхөд засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

- Түүнчлэн, НҮБ нь бодлогын бусад чиглэлээр дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн удирдлага, цалин, хүнс хөдөө аж ахуй, худалдаа, жижиг дунд үйлдвэр, экспортын төрөлжилт, брэнд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого, хууль тогтоомжийг олон улсын стандарттай нийцүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд экспортыг нэмэгдүүлж, бараа бүтээгдэхүүний импортыг багасгах бодлого боловсруулахад Засгийн газарт туслалцаа үзүүлнэ.

Хамтран оролцогч талууд: Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, бусад холбогдох яамд болон иргэний нийгмийн байгууллагууд.

Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар Зохицуулах хороо байгуулах, эсвэл ҮБ -ын байгууллагуудын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж болно.

Тэргүүлэх чиглэл 2: Нийгмийн суурь үйлчилгээ ба нийгмийн хамгаалал

Энэхүү тэргүүлэх чиглэлийн дагуу НҮБ-ын системийн байгууллагууд нь Монгол дахь ядуурлын олон талт шинж чанар, нийгмийн суурь үйлчилгээ, хамгааллын тогтолцооны хүртээмж тэгш бус байдал болон нийгмийн хамгааллын тогтвортой хөтөлбөр дутмаг байгаа асуудлуудыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх болно. Түүнчлэн, нийгмийн халамж, даатгалын тогтолцоо, зохистой ажлын байрны санаачлагууд, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах болон хүүхэд хамгааллын санаачлагууд зэрэг нийгмийн хамгааллын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь урт хугацааны ач холбогдолтой.

Энэхүү тэргүүлэх чиглэлийн үндэслэл нь эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ус хангамж, ариун цэвэр болон эрүүл ахуйн салбарын⁸ үйлчилгээний чанар болон хөгжлийн тогтвортой үр дүн, ахиц дэвшил хангалтгүй байгаатай холбоотой. Нийгмийн үйлчилгээний эдгээр салбарт дараах дөрвөн түгээмэл асуудал тулгамдаж байна:

- Үр дүнтэй бодлого, стратеги, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх
- Удирдлага, төлөвлөлтийн чадавхи, хүн хүчний болон санхүүгийн нөөц зэрэг нийгмийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэхэд шаардлагатай бүтэц, механизмыг бий болгох замаар үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБХС	2,910,600	11,642,400
ДЭМБ	8,300,000	8,500,000
НҮБХАС	4,470,000	3,200,000
НҮБ-Хабитат	680,000	2,320,000
НҮБ ХХ	100,000	1,500,000
НҮББШУСБ	1,200,000	800,000
ОУХБ	185,000	450,000
НҮБ-ын ДОХ-ын хөтөлбөр	-	1,000,000
Бүгд	17, 845,600	29,412,400

⁸ Монгол дахь НҮБ: Улс орны нийтлэг үнэлгээ, 2012-2016 (2010 оны 4-р сар), Ядуурал 11, Боловсрол 27, Эрүүл мэнд 56

- Хувь ~~үн~~, гэр бүл, олон нийтийн мэдлэг, ойлголтыг ~~дээрх~~, чадавхийг хөгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх
- Онцгой үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах асуудлуудыг бодлогод тусгах

Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог дэмжих, МХЗ-уудын хэрэгжилт, ололтуудыг тогтворжуулах үндэсний чадавхийг бий болгох явдал чухал ач холбогдолтой. Боловсрол, эрүүл мэнд, ус хангамж, ариун цэвэр болон эрүүл ахуйн салбарын санхүүжилт хот суурин газруудад голлон төвлөрч байгаа нь шаардлагатай чадавхийг хөгжүүлэхэд саад бэрхшээл болж байна. Ирэх жилүүдэд уул уурхайн салбарын үйл ажиллагаа улсын төсвийг нэлээд бэхжүүлэх төлөвтэй тул нийгмийн зардал дахь тэгш бус байдлыг шийдвэрлэх боломж байна.

Энэ тэргүүлэх чиглэлийн үр дүн нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4 тэргүүлэх чиглэл болон МХЗ 1,2,4,5,6,7-н хэрэгжилттэй холбоотой болно:

- Эцэг, эхчүүд үр хүүхдээ эрүүл саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх
- Суралцагчдад ~~хүртээмжтэй~~, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх
- Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, хүн амаа өсгөх бодлого баримтлах
- Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулах
- Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх
- Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх
- Ажлын байрны аюулгүй орчинг хангаж, ажлын байран дахь осол гэмтлийг багасгах

Үүнээс 4 үр дүн хүлээгдэж байна:

ҮРДҮНЗ Эмзэг бүлгийн х үн амд чиглэсэн боловсролын чанар ба хүртээмж сайжирсан байна

Эмзэг бүлгийнхэнд чанартай боловсрол олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд НҮБ-ын байгууллагууд нь:

- Боловсролын бодлогын хяналт, төлөвлөлт, удирдлагаар хангах үндэсний чадавхийг бэхжүүлэх

- Хамгийн эмзэг бүлгийн буюу үндэсний цөөнх, шилжин суурьшсан, хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн суралцах боломжийг нэмэгдүүлэх
- Хүний эрхэд суурилсан, хүүхдэд ээлтэй сургуулиудыг дэмжиж, багш бэлтгэх сургалтыг сайжруулан, сургуулийн удирдлага, шийдвэр гаргах үйл явцад сурагчдын оролцоог нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийг сайжруулах замаар боловсролын чанарыг сайжруулах
- Тогтвортой хөгжил болон гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг боловсролын салбарт нэвтрүүлж, гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах зохицуулалтын механизмыг бий болго

Хэрэгжүүлэх гол түншүүд:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалалтын яам, орон нутгийн засаг захиргаа, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын үндэсний хороо. Зохицуулалтын тусгайлсан механизмыг бүрдүүлэхэд оролцох талууд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хамтран тэргүүлсэн Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх механизм, Азийн хөгжлийн банк болон Японы ЭСЯ болно.

ҮРДҮН4. Хотын гэр хороолол ба хөдөө орон нутгийн хүн амын найдвартай ус хангамж, ариун цэврийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангасан байна

Эмнэлэг, эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудыг найдвартай цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх нь нэн тулгамдсан, бэрхшээлтэй асуудал болж байна. НҮБ нь чанартай үйлчилгээ үзүүлэх талаар тухайн салбарын чадавхийг бэхжүүлэх болон шинэлэг, “ногоон” технологи, аргачлал нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, зохицуулалт, төлөвлөлт, удирдлага тэр дундаа онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах асуудалд анхаарал хандуулна.

Боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын дэдүбэц болон үйлчилгээг сайжруулах туршилтын төслүүдийг боловсруулан, сонгосон эмзэг бүлгийн олон нийтийн дунд хэрэгжүүлж, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ. Эдгээр хүчин чармайлт ыгдэмжих зорилгоор нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулах, мэдлэг бүтээх, ухуулга нөлөөлөл явуулах, шаардлагатай нөөцөөр хангах үйл ажиллагааг явуулна. Олон нийтийн түвшинд, ард иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, хувь хүн, айл өрх болон олон нийтийн чадавхийг хөгжүүлнэ.

НҮБ-ын байгууллагууд нь:

- Ундны цэвэр ус болон эрүүл ахуй, ариун цэврийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангах, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, зохицуулалт болон төлөвлөлтийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар засгийн газрын бодлогод дэмжлэг үзүүлнэ.
- Чанартай үйлчилгээ үзүүлэх, шинэлэг технологи, аргачлал ашиглан үр нөлөөний хяналт шинжилгээ хийх талаар салбарын чадавхийг дээшлүүлнэ.

- Сонгогдсон эмзэг бүлгийн олон нийт, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудад иргэдийн манлайлал бүхий үйл явцад тулгуурлан шинэ дэд бүтэц болон үйлчилгээг туршин хэрэгжүүлнэ.
- Ус хангамж, ариун цэвэр болон эрүүл ахуйн салбарт гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, холбогдох талууд онцгой байдлын стандарт журмын дагуу хариу арга хэмжээ авахад бэлэн байхад чиглэн ажиллана.

Хэрэгжүүлэх гол түншүүд:

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, орон нутгийн захиргаад, Шинжлэх ухааны академи, судалгааны хүрээлэн, их дээд сургууль, коллежууд, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагууд болно. Засгийн газрын манлайлал дорүндэсний зохицуулах тусгай механизмыг байгуулах. Хөдөөгийн ус хангамж, ариун цэвэр ба эрүүл ахуйтай холбогдох асуудлаар НҮБ-ын Ус хангамж, үүл ахуйн хамтарсан өхөлбөрийн хүрээнд НҮБ -ын өрөлжсөн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжүүлнэ.

ҮРДҮН 5. Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний х үртээмж болон ашиглалт нэмэгдсэн байна

НҮБ-ын байгууллагууд нь:

- Эрүүл мэндийн салбарын зохицуулалт, түншлэл, удирдлагыг үндэсний болон орон нутгийн төвшинд бэхжүүлж, салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, хүн амын тодорхой хэсэгт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх чиглэлээр ухуулга нөлөөлөл явуулна.
- Эхийн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Нярайн болон хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийг сайжруулах арга хэмжээний чанар болон эрэлт хэрэгцээг сайжруулна.
- ХДХВ, ДОХ, БЗДХ, сүрьеэтэй тэмцэх салбар хоорондын болон ажлын байрны арга хэмжээг сайжруулна.
- Жендэрийн тэгш бус байдал, хүрээлэн буй орчны бохирдол, онцгой үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зэрэг эрүүл мэндийн гол хүчин зүйлсийг шийдвэрлэх замаар эрүүл мэндийг сайжруулна.

Хэрэгжүүлэх гол түншүүд:

Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, өнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн захиргаад, иргэний нийгмийн байгууллагууд болно. Зохицуулалтын

тусгай механизм нь: (а) Эрүүл мэндийн дэд сайд ахласан Тусламжийн зохицуулалтын хороо – энэ хороо нь , тус яамны газрын дарга нарын тэргүүлсэн 8 ажлын хэсгээс бүрдэнэ. (б) Эх, нялхсын эрүүл мэндийн асуудлаарх НҮБ-ын Ажлын хэсэг (в) НҮБ ба ДОХ-ын эсрэг үндэсний хорооны хамтран тэргүүлэх ХДХВ, ДОХ, БЗДХ-тай тэмцэх сэдэвчилсэн багийн хурал, (г) Глобаль сангийн төслүүдийн Зохицуулах механизмаас тус тус бүрдэнэ.

ҮРДҮН 6 Эмзэг бүлгийнхэнд онцгой анхааран нийгмийн хамгааллыг бэхжүүлж өргөжүүлсэн байна

Хэдийгээр Монгол Улсын Засгийн газраас нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх тал дээр хүчин чармайлт гаргаж, болоцооны хэрээр өсөв хувиарлаж байгаа хэдий ч зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийт хүн ам, тэр дундаа эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээ дутмаг байгаа билээ. Иймээс энэ хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхийн тулд НҮБ-ын байгууллагууд нь:

- Ядуурал ба тэгш бус байдалд дүн шинжилгээ хийхэд тусламж үзүүлэх, нийгмийн хамгаалал, нийгмийн хамгааллын тогтолцоо, түүний дотор хөдөлмөр хамгаалал ба эрүүл ахуйтай холбоотой асуудлаар бодлого, хууль тогтоомж боловсруулахад техникийн туслалцаа үзүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшигчид, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настнуудын эрхтэй холбогдох олон улсын стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үндэсний болон орон нутгийн чадавхийг бэхжүүлнэ. .
- Урьдчилан сэргийлэхээс хариу арга хэмжээ авах хүртэл цогц үйлчилгээ үзүүлэх замаар жендэрт суурилсан болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогчдод тусламж үзүүлэх чадавхийг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх гол түншүүд:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам (НХХЯ), нийгмийн даатгал, нийгмийн халамж, ажил эрхэлт ба хөдөлмөрийн зах зээлийн асуудал хариуцсан гүйцэтгэгч ба зохицуулагч агентлагууд байна. ҮНБ -ын байгууллагууд, Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотой НҮБ-ын ажлын хэсгийг байгуулж, зохицуулалтыг хангана.

Тэргүүлэх чиглэл 3: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдлийг бууруулах

Монгол орон уур амьсгалын эрс тэс нөхцөл, өргөн уудам нутаг дэвсгэртэй бөгөөд хүрээлэн буй орчны хувьд арвин баялагтай билээ. Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ-ын байгууллагууд эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тогтвортой хөгжлийн арга хэмжээтэй хослуулах тал дээр Засгийн газрыг дэмжин ажиллана. Үүний тулд өмнөх үйл ажиллагааны батлагдсан туршлага, ололтод суурилан байгалийн нөөцийн менежмент болон хот төлөвлөлтийн чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшигт бэлэн байх, хор хохирлыг бууруулах чадавхийг сайжруулах, эрчим хүч болон нөөц ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, хот суурингийн агаарын бохирдлыг багасгах болон хог хаягдлын менежментийн шинэ болон шинэлэг арга технологийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай.

Шаардагдах хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБХХ / НҮБСДБ	1,900,000	12,600,000
НҮБХС	110,000	440,000
НҮББОХ	157,000	240,000
НҮБАҮХБ	50,000	500,000
ОУХБ	45,000	50,000
ДЭМБ	390,000	600,000
НҮББСШУБ	50,000	425,000
НҮБХХААБ	1,750,000	5,800,000
НҮБ-Хабитат	150,000	350,000
ОУЦЭА	1,000,000	1,000,000
НИЙТ	5,602,000	22,005,000

Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ -ын төрөлжсөн байгууллагуудын үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулах, түүнд дасан зохицох чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх асуудал голлох байр суурь эзлэх юм.

Энэхүү тэргүүлэх чиглэлийг авч үзэхийн учир нь хоорондоо уялдаа холбоо бүхий усны хомсдол, хотын агаарын бохирдол, бэлчээрийн доройтол, цогц хэмжээний уурхайнуудын хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй нөлөөлөл зэрэг тулгамдсан асуудлуудтай холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлж, зохицуулалтыг сайжруулах шаардлага юм⁹. Үүний зэрэгцээ байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт сул, холбогдох агентлагуудын хоорондын зохицуулалт хангалтгүй, санхүүжилт дутмаг байдал, мөн байгаль хамгаалахад өгч буй ач холбогдол бага байгаа нь байдлыг улам хүндрүүлж байна.

Энэ тэргүүлэх чиглэлээс гарах үр дүнгүүд нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын МХЗ 7-той холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

- Бохирдлыг багасгах
- Газар, ашигт малтмал болон усны нөөцийг зохистой ашиглах
- Ургамал амьтны төрөл зүйлийн хорогдлыг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
- Олон улсын байгаль орчны гэрээ, конвенциудыг дагаж мөрдөх (ҮХЦБ, 6)

⁹ Монгол дахь НҮБ: Улс орны нийтлэг үнэлгээ 2012-2016, Хүрээлэн байгаа орчин 72, 82-83

- Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх (ҮХЦБ 5.3.2)
- Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигт нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн механизмыг бий болгоход хувь нэмэр оруулна.

Тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд БОАЖЯ, ЗТБХБЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ, БСШУЯ болон түүний хэрэгжүүлэгч агентлагууд, ЭМЯ болон яамдын харьяа хэрэгжүүлэгч агентлагууд, БОАЖЯ, ОБЕГ, орон нутгийн засаг захиргаад, Шинжлэх ухааны академи, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн нөөцийг ашиглагчид зэрэг талуудтай голлон хамтарч ажиллана.

Зохицуулалтын механизмд яам хоорондын ажлын хэсэг, хороод, тухайлбал Усны үндэсний хороо, Уур амьсгалын өөрчлөлтийн болон цөлжилттэй тэмцэх үндэсний хороо, Бэлчээрийг зохицуулах ажлын хэсэг, үндэсний хэмжээний онцгой байдлын бүлгүүд орох бөгөөд тэдгээрийн чиглэлийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ -ын төрөлжсөн байгууллагуудын дэмжлэгтэйгээр өргөжүүлэх болно. НҮБ -ын хамтарсан хөтөлбөрүүдийг тодорхой асуудлаар, ялангуяа байгаль орчны засаглалын чиглэлээр хуралчлал үйл ажиллагааны үр ашиг дээшлэх юм.

Уг тэргүүлэх чиглэлийн хүрээнд гурван үр дүн гарна:

ҮРДҮН 7. Үндэсний болон орон нутгийн түвшинд байгалийн нөөц баялгийг анхан шатны хэрэглэгчдийн оролцоог хангаж, тогтвортой ашиглах салбарын чадавхи бүрэлдсэн байна

Үндэсний ба орон нутгийн түвшинд байгаль орчны тогтвортой байдлын төлөвлөлт, удирдлага, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх бөгөөд холбогдох хууль дүрмийг мөрдүүлэх тал дээр хяналт тавих, байгалийн нөөцийн менежментэд орон нутгийн нөөц ашиглагчдын оролцоог хангахад онцгойлон анхаарна. Ингэхдээ, байгалийн нөөцийг ашиглах хамгаалах цогц хандлагыг (ландшафт болон экосистемд суурилсан) үлхүү ашиглана. Биологийн олон янз байдлын болон Уур амьсгалын өөрчлөлт, Цөлжилттэй тэмцэх конвенциуд, тэдгээрийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгайлан дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд нь:

- Үндэсний болон орон нутгийн түвшинд байгаль орчны салбарын бодлого, хууль тогтоомжийг боловсруулж төлөвлөн хэрэгжүүлэх, мөрдүүлэх, тайлагнах ба удирдан зохицуулах чадавхийг бэхжүүлэх
- Газар, ус, ойн нөөц, биологийн олон янз байдлын төлөвлөлт, удирдлага болон хамгаалалтад ландшафт болон экосистемд суурилсан цогц хандлагыг нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулна.

ҮРДҮН 8. Үндэсний болон орон нутгийн түвшинд байгалийн ба хүний хүчин з үйлээс үүдэлтэй гамшгийн эрсдэл, үр дагаварыг бууруулсан байна

2009-2010 оны зудын сургамжаас гамшгийн бэлэн байдал, удирдлага зохицуулалтыг олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийг оролцуулав. Түвшинд сайжруулах шаардлагатай байгаа нь харагдсан. Газарөдлөлт, үер болон бусад гамшгуудад өртөмхий байгааг харгалзан тус салбарын бодлого, өтөлбөрүүдэд Хюгогийн зарчмыг тусгах зайлшгүй шаардлага тулгарч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагав арын талаарх ойлголтыг сайжруулах нь дасан зохицох эн тэрүүний боломжит хувилбаруудын үр ашгийг, ялангуяа эмзэг салбар болон бүлгийн хувьд тодорхойлоход онц чухал болоод байна.

Энэ чиглэлээр, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ -ын байгууллагууд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Салбар хоорондын төлөвлөлт, зохицуулалт, холбоо харилцаа, мэдээлэл солилцооны түвшинд үндэсний хэмжээний үйл ажиллагааны чадавхи сайжрах
- Эмзэг бүлгийг онцгойлон анхаарч, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон дасан зохицох боломжит сонголтуудад дүн шинжилгээ хийх
- Хөдөө аж ахуйн салбарын гамшгийн бэлэн байдал сайжрах

Орон нутгийн түвшинд сайн дурынхны оролцоог хангах нь дээрх үр дүнд хүрэх боломжит арга хэрэгслийн нэг болох юм.

ҮРДҮН 9. Эрчим хүчний үр ашгийг сайжруулах, ногоон өсөлтийг хангаж, хотын агаарын бохирдлыг бууруулах шинэ технологи нэвтрүүлсэн байна

‘Ногоон’ эдийн засгийн өгжлийн үндсийг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, ялангуяа хот суурингийн тогтвортой өгжлийг хангах зорилгоор хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, эрчим хүч болон байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх чадавхийг сайтар бэхжүүлэх хэрэгтэй байна. Органик гаралтай Удаан Задардаг Бохирдуулагч Бодисын Конвенц болон Копенгагений гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг НҮБ -ын байгууллагууд дараах ажлуудыг хийнэ:

- Хот суурингийн агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүч, байгалийн нөөц баялгийг үр дүнтэй ашиглах чиглэлээр Ногоон Хөгжлийн бодлого болосвсруулахад дэмжлэг үзүүлэх,

- Монгол орны нөхцөлд тохирсон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг дэмжих,
- Хатуу болон аюултай хог хаягдлын менежмент сайжирч, Удаан Задардаг Бохирдуулагч Бодисын хэмжээг бууруулах.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4: Засаглал ба хүний эрх

Ардчилсан засаглалыг хөгжүүлж, хүний эрхийг баталгаажуулах явдал нь Мянганы хөгжлийн бусад бүх зорилтуудад хүрэх суурь нөхцлийг бүрдүүлдэг болохыг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Их Хурал хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлж, авлигатай тэмцэх Мянганы хөгжлийн бие даасан 9 дэх зорилтыг баталсан билээ.

Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын байгууллагууд засаглалын чанар болон хөгжлийн үр дүнгийн тэгш хуваарилалтын хоорондын уялдааг сайжруулж, хүний эрхийг хангахад гол анхаарлаа хандуулах бөгөөд авлигатай тэмцэж, НҮБ энэ чиглэлээр ажиллахын гол үндэслэл нь ядуурлыг бууруулахад оршино.

Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБХХ	4, 690, 000	3, 550, 000
НҮБХАС	1, 600, 000	1, 150, 000
НҮБХС	600, 000	2, 400, 000
НҮБ-ын Дүрвэгдсийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газар	35, 000	80, 000
НҮББШУСБ	50, 000	50, 000
НҮБ-Хабитат	100, 000	300, 000
НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр	-	150, 000
ОУХБ	180, 000	250,000
НИЙТ	7,255,000	7,930,000

Сонгуулийн тогтолцоонд хийгдэж буй шинэтгэлд дэмжүүлэх замаар, үр дүнтэй удирдлагаар хангах чадавхи бүхий илүү олон талын төлөөлөлтэй парламентыг бүрдүүлж, хөгжлийн бодлого боловсруулалт дахь эрх баригчдын үүрэг, оролцоог сайжруулна. Ядуу болоод гадуурхагдсан иргэдийн ашиг сонирхлоо илэрхийлэх, зохион байгуулалттайгаар шүүхэд гомдол мэдүүлэн, маргаанаа шийдвэрлүүлэх, амьжиргааны боломжоо нэмэгдүүлэх чадавхитай болгох замаар хууль хүн бүрт тэгш шударга үйлчлэх нөхцлийг сайжруулна.

Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүрэх үр дүнгүүд нь Мянганы хөгжлийн 3 болон 9 дэх зорилтуудтай холбоотой Үндэсний хөгжлийн цогц бодлогын дараах 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүнд:

- Бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах
- Улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлэх
- МХЗ 3: Жендэрийн тэгш байдлыг дэмжиж, эмэгтэдийг чадавхижуулах (МХЗ 3, зорилт 8)
- МХЗ 9: Хүний эрхийг баталгаажуулж, ардчилсан засаглалыг хөгжүүлэх (МХЗ 9, зорилт 22,23,24).

Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах 4 үр дүнд хүрэхийг зорино:

ҮРДҮН10. Төв ба орон нутгийн засаг захиргааны түвшинд нотолгоонд суурилсан төлөвлөгөө, төсөв боловсруулах, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи дээшилсэн байна

Аливаа орны хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, бүтэц, амьжиргааны түвшин, тархалт, байгалийн нөцийн талаарх баримт мэдээллүүд нь холбогдох бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж, үнэлэхэд чухал ач холбогдолтой. Монгол улс эдгээр тоон мэдээ, мэдээллүүдийг хүн амын тооллого, статистик судалгаа, МХЗ-уудын хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэл зэргээр дамжуулан олж авахад дорвитой ахиц гаргасан юм. Гэвч нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулахын тулд цуглуулсан тоон мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнтэй ашиглах талаар цаашид ихийг хийх шаардлагатай байна. МХЗ-уудын хүрээнд НҮБ-ын байгууллагууд Засгийн Газрын агентлагуудтай хамтран ажиллаж, баримтад тулгуурласан бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, төлөвлөгөө, стратегиудыг үнэлж, уялдааг ханган, МХЗ-уудын хэрэгжилтийн үйл явцыг дүгнэхийн тулд харьцуулж болохуйц статистик мэдээ мэдээллийг тогтмол олж авахад нь дэмжлэг үзүүлнэ.

НҮБ-ын байгууллагууд нь:

- Үндэсний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийг боловсруулахад шаардлагатай, хүйсээр задлан ангилсан, бодитой, чанартай тоон, мэдээ мэдээллийн олдоц, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Үр дүнд тулгуурласан хяналт үнэлгээ хийх чиглэлээр Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чадавхийг бэхжүүлэх;
- Үндэсний хөгжлийн цогц бодлого болон МХЗ-уудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах замаар МХЗ-уудын хэрэгжилтийг эрчимжүүлэх.

Гол хэрэгжүүлэгч байгууллагууд: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон чиглэлийн яамд. DevInfo программыг цаашид МХЗ-уудтай холбоотой мэдээллийн сангийн удирдлага, зохицуулалтын талбар хэлбэрээр үргэлжлүүлэн ашиглана.

ҮРДҮН 11. Засаглалын байгууллагуудын төлөөлөл, хариуцлага ил тод байдал дээшилсэн байна

НҮБ-ын байгууллагууд нь Монгол улсад ардчилалыг бэхжүүлэхэд а нхаарах бөгөөд нэн ялангуяа засаглалыг сайжруулж, улс төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулж, эрх тэгш байдлыг ханган, төрийн байгууллагуудын шударга, нээлттэй, ил тод байдлыг сайжруулахад гол анхаарлаа хандуулна.

НҮБ-ын байгууллагууд нь:

- Илүү бодитой, шударга сонгууль явуулах чиглэлээр Сонгуулийн ерөнхий хорооны чадавхийг сайжруулж, үрэм, журмуудыг боловсронгуй болгож, сонгогчдын боловсрол, оролцоо, иргэдийн хяналтыг сайжруулахад түлхүү анхаарна;
- Төвлөрлийг үр дүнтэй сааруулж, нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны чадавхийг сайжруулах бодлогын орчинг бий болгоход дэмжлэг үзүүлнэ;
- Авлигын эсрэг НҮБ -ын конвенц болон 2006 онд батласан Авлигын эсрэг Монгол улсын хуулийг хэрэгжүүлэх Авлигатай тэмцэх газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлнэ;
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж, нэн ялангуяа төвийн болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргахүйл явцад оролцох эрхийг нь хангахад дэмжлэг үзүүлнэ.

Гол хэрэгжүүлэгч байгууллагууд: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, орон нутгийн засаг захиргаа, Монгол Улсын Их Хурал, Сонгуулийн ерөнхий хороо, Авлигатай тэмцэх газар

ҮРДҮН12. Хүний эрхийг дэмжиж, хамгаалах үндэсний тогтолцоо сайжирсан байна

Энэ үр дүнгийн хүрээнд НҮБ -ын байгууллагууд нь олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцууд түүний дотор олон улсын гэрээний хэрэгжилтийг хянах шинжээчдийн хороод болон хүний эрхийн төлөв байдлын тогтмол үгээмэл хяналт зэрэг бусад хяналтын механизмуудаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь Монгол улсад дэмжлэг үзүүлнэ. 2010 оны Хүний эрхийн төлөв байдлын тогтмол түгээмэл хяналтын үеэр оролцогч орнууд хүний эрхийн асуудлууд түүний дотор ядуурал ажилгүйдэл, авлигаас үүдэлтэй төрийн үйлчилгээний доройтол, эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагын талаарх хуучинсаг хэвшмэл ойлголт амь бөхтэй хадгалагдсаар байгаа явдал, охид эмэгтэйд худалдаалах, мөлжих явдал газар авч, буруутай этгээдүүд тэр бүр хариуцлага хүлээдэггүй, орон гэргүй иргэд болоод хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоо өсч, үндсэрхэг үзэл гаарч, хүн амын цөөнх түүний дотор гей, лесби, бисекс, транссексуал иргэдийг ялгаварлан гадуурхаж байгаад санаа зовниж буйгаа илэрхийлэв.

Энэхүү үр дүнгийн хүрээнд НҮБ нь дараах дэмжлэгийг үзүүлнэ:

- Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чадавхийг сайжруулах
- Парламент, иргэний нийгмийн удирдлага, хяналтын үйл ажиллагаа, төрийн албан хаагчид, боловсролын байгууллага, хувийн хэвшлийн ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалт
- Хүний эрхийн гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянаж, тайлагнах үндэсний тогтолцоо

- Хүний эрхийн талаарх ухуулга нөлөөлөл, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, бодлого боловсруулах
- Эрх зүйн тусламж үзүүлэгч сайн дурын ажилтнуудын дэмжлэгтэйгээр ядуу болоод бусад гадуурхагдсан бүлгийнхний эрх зүйн чадавхийг сайжруулах замаар хууль хүн бүрт тэгш шударга үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх

Гол хэрэгжүүлэгч байгууллагууд: УИХ, Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам болон чиглэлийн яамд. Тусгай зохицуулалтын механизмууд нь Ерөнхий сайдаар ахлуулсан “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хороо, Хүний эрхийн үндэсний комисс, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо.

ҮРДҮН13. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, жендэрийн асуудлыг бодлого, хөтөлбөрт тусгах чадавхи сайжирсан байна

Хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдэд олгож буй цалин хэт бага, улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хомс, жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн бэлгийн болон юхон үржихүйн эрүүл мэнд ийн тулгамдсан асуудлууд зэрэг эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж¹⁰ буй асуудлуудыг шийдвэрлэхэд шинэлэгчлэн чармайлт гаргаж ажиллах шаардлагатайг Монгол улсын нөхцөл байдлад хийсэн ерөнхий үнэлгээнд цохон тэмдэглэсэн байна. Жендэрийн тэгш байдлыг хангах явдал нь стратегийн 4 тэрүүлэх чиглэлтэй холбоотой тул НҮБ-ын байгууллагууд дараах 4 үйл ажиллагааг хэрэгжүүлж, энэхүү үр дүнд хүрэхэд хувь нэмрээ оруулна. Үүнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгохын төлөө ухуулга нөлөөлөл хийх,
- Эмэгтэйчүүд нэн ялангуяа охид, бүсгүйчүүдийг чадавхижуулж орон нутгийн болон үндэсний бодлогыг идэвхитэй сонирхдог болгох,
- Эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний эрхийн өлөө ухуулга, нөлөөлөл хийх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг сайжруулж, жендэрт суурилсан хүчирхийллийг устгахад онцгойлон анхаарах,
- Үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулахад жендерийн асуудлыг тусгах чиглэлээр бодлого боловсруулагчдын чадавхийг сайжруулах.

Гол хэрэгжүүлэгч түнш байгууллагууд:

¹⁰ Ялгаатай байдлыг бууруулах нь, Монгол улс дахь НҮБ, Монгол улсын нөхцөл байдалд хийсэн ерөнхий үнэлгээ 2012-2016, Жендэр 49-53.

Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо, чиглэлийн яамд, орон нутгийн засаг захиргаа. Тусгай зохицуулалтын механизмууд нь: МБ -ын Жендэрийн сэдэвчилсэн бүлэг, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо

3.0. НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнээс гадуур хэрэгжүү лэх үйл ажиллагаа

НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ нь Монгол Улсын Засгийн газар болон ҮБ -ын байгууллагуудын хамтын хүчин чармайлтаар Үндэсний хөгжлийн цогц бодлого болон МХЗ -дын тэрүүлэх чиглэлийн биелэлтийг хангах үр дүнгийн хүрээ юм. Үүгээр НҮБ -ын байгууллагуудын нөөц бололцоо болон хуримтлуулсан туршлагын харьцангуй давуу талыг илэрхийлж байгаа болно. Харин өмнөх байдал өөрчлөгдөж НҮБ -ын ХТХ-нээс гадна шинэ хэрэгцээ, шаардлага гарсан тохиолдолд Засгийн Газраас тодорхойлж гаргасны дагуу нэмэлт дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

Эдгээрийг НҮБ-ын тухайн төрөлжсөн байгууллагын мандат болон санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран, дангаараа эсвэл хамтарсан төслийн хэлбэрээр дэмжинэ. Тухайлбал, гадаадын зээл, тусламжийн зохицуулалт эсвэл уул уурхайн салбарын хөгжлийг дагасан үр дагавар зэрэг байж болно. Мөн түүнчлэн МХЗ-уудыг хэрэгжүүлэх шинэ эх сурвалж болон бусад ҮБ -ын Итгэлцлийн Сангуудаас шинээр үүсгэн байгуулж бий болсон тохиолдолд НҮБХТХ-нээс гадуур хэрэгжих хамтарсан үйл ажиллагааг санхүүжүүлж болно.

4.0 Шаардагдах санхүү жилт

НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Хүрээний тэргүүлэх чиглэл, үр дүнг дэмжихэд шаардагдах боломжит болон дайчлах шаардлагатай санхүүгийн нөөц эх үүсвэрийг дараах байдлаар тоймлон харууллаа. Үүнд:

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БА ҮР ДҮН	Шаардлагатай санхүүжилт (ам. доллар)	
	Боломжит	Дайчлах
Тэргүүлэх чиглэл 1: ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	3,381,850	5,700,000
Үрдүн 1	2,110,000	3,640,000
Үрдүн 2	1,271,850	2,060,000
Тэргүүлэхчиглэл 2: НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭ БА НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	17,845,600	29,412,400
Үрдүн 3	1,989,800	4,429,200
Үрдүн 4	1,220,800	5,583,200
Үрдүн 5	14,105,000	18,030,000
Үрдүн 6	530,000	1,370,000
Тэргүүлэхчиглэл 3: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ	5,602,000	22,005,000
Үрдүн 7	2,269,000	10,970,000
Үрдүн 8	2,290,000	5,605,000
Үрдүн 9	1,043,000	5,430,000
Тэргүүлэхчиглэл 4: ЗАСАГЛАЛ БА ХҮНИЙ ЭРХ	7,255,000	7,930,000
Үрдүн 10	3,140,000	2,260,000
Үрдүн 11	2,630,000	3,370,000
Үрдүн 12	1,205,000	1,970,000
Үрдүн 13	280,000	330,000
НИЙТ	34,084,450	65,047,400

Эдгээр нь нэгдүгээрт, НҮБ -ын байгууллага тус бүрийн хөтөлбөрийн, хоёрдугаарт, НҮБХТХ-ний байгууллагууд ХТХ-ний хэрэгжилтийн явцад дайчлах боломжтой гэж тооцож байгаа эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Эдгээр эх үүсвэрийн тооцоог НҮБХТХ-г боловсруулах явцад аль болох бодитоор тооцоолж гаргасан болно. Тухайн оронд хэрэгжих НҮБ -ын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдийг удирдах дээд байгууллагууд баталсаны дараа санхүүжилтийн эх үүсвэр нь дагалдан батлагддаг. Мөн түүнчлэн ирэх жилүүдэд Засгийн газрын төсвийн хэмжээ нилээд хэмжээгээр өсөх хандлагатай байгаа тул Засгийн газартай хамтран санхүүжүүлэх зохицуулалтыг эрэлхийлэх боломж бий болох билээ. Нэмэлт санхүүжилтыг харгалзан НҮБХТХ-ний төсвийг жил бүр шинэчлэн хянаж байх болно.

Үр дүнгийн биелэлтийг хангах хариуцлагыг Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын байгууллагууд хамтран хүлээнэ. Хүлээгдэж буй үр дүнд зөвхөн НҮБ-ын санхүүжилтээр хүрэх боломжгүй бөгөөд Засгийн Газраас болон бусад эх сурвалжаас нэмэлт санхүүжилт хайх хамтын хүчин чармайлт шаардлагатай юм.

5.0 Хэрэгжилт

НҮБХТХ-ний хэрэгжилтийг НҮБ-ын байгууллагууд, Монгол улсын Засгийн газар өөрийн харьяа яамдууд болон хэрэгжүүлэгч агентлагуудаараа дамжуулан хариуцна. Мөн хэрэгжилтэд Их Хурал, иргэний нийгмийн байгууллагууд, сургалт, судалгааны байгууллагууд, хувийн сектор идэвхитэй оролцоно.

НҮБ-ын байгууллагуудаас оруулах хувь нэмэр нь тэдгээрийн Засгийн газартай байгуулсан Хамтын ажиллагааны Хөтөлбөрүүдэд тусгагдсанаар баталгаажина. Хэрэгжилтийг цаг хугацаанд нь, үр дүнтэй гүйцэтгэх нь НҮБ-ын байгууллага түрийвч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хариуцлага байх болно.

НҮБХТХ-ийн хэрэгжилтийг Гадаад харилцааны сайд болон МБ-ын Суурин зохицуулагч нараар ахлуулсан НҮБХТХ-ний Хяналтын Хороо хариуцна. Хорооны гишүүд нь НҮБ-ын ХТХ-г хэрэгжилтэд оролцож буй Засгийн Газрын холбогдох ахлах ажилтнууд болон Н-ын байгууллагуудын тэргүүн нар байна.

НҮБ ХТХ-ний ажлын хэсгүүд тэргүүлэх чиглэл тус бүрээр байгуулагдана. Тэдгээр нь:

- Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, зохицуулалт хийнэ.
- НҮБХТХ-ний үр дүнг хэмжиж, хяналтыг үр дүнтэй явуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- НҮБХТХ-ний Удирдах Хороонд хэрэгжилтийн явцыг тайлагнана.
- Хэрэгжилт нь үний эрхэд суурилсан, жендэрийн тэгш байдал болон хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангасан хандлагыг баримталсан эсэхийг нягтална.
- Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судална.

НҮБХТХ-ний хэрэгжилтийн үндэс нь үндэсний хэмжээнд чадавхийг нэмэгдүүлэхэд оршино. Хэрэгжүүлэгч байгууллагын чадавхийг нэмэгдүүлэхийн тулд ажилтан сонгон шалгаруулах, бараа, үйлчилгээ худалдан авах, сургалт зохион байгуулах, бүртгэл тооцоо, бэлэн мөнгө тараалтын зохицуулалт, санхүүгийн тайлан зэрэг захиргааны болон санхүүгийн ажлын гүйцэтгэл зэрэг хэрэгжилтийн бүх шатанд анхааран ажиллана. НҮБ-ын байгууллага өсөл хэрэгжүүлсэн тохиолдолд тухайн байгууллага төсвийн зохицуулалтад хариуцлагатай хандах болон төслийн хаалтын стратегийг тодорхой боловсруулах зэрэг дээр хоёр тал тохиролцсон байна.

6.0 Хяналт шинжилгээ, үнэлгээ

НҮБХТХ-нд үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэл, МХЗ-ууд, үр дүн, үйл ажиллагаанууд багтана. Хяналт нь хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлт, зорилтод тулгуурлан гүйцэтгэлийг 3 түвшинд үнэлнэ.

Үйл ажиллагааны түвшинд хяналтыг тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй НҮБ -ын байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллага явуулах бөгөөд газар дээрх шалгалт, холбогдох талуудын уулзалт, баримт бичгийн судалгаа, тайлангуудад суурилан явуулна.

Үр дүнгийн түвшинд НҮБХТХ-ний ажлын хэсэг болон хамтарсан хөтөлбөрийн багууд хяналтыг явуулна. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд эзэн болж хандах байдлыг дэмжихийн тулд үр дүнг тооцох түвшний үзүүлэлтүүдийг аль болох Үндэсний хөгжлийн цогц бодлогын үзүүлэлтэд нийцүүлэх, үндэсний хэмжээний хяналт, шинжилгээ үнэлгээний явц болон тайлангууд нь МБ ХТХ-ний хяналт, үнэлгээний үндэс болно. НҮБ нь хөгжлийн үр дүнг хэмжих, МХЗ-уудад хүрсэн эсэхийг хэмжих, мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, цуглуулсан мэдээллийг хэрхэн ашиглах тал дээр засгийн газрын байгууллагуудын үүнд: Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зэрэг багтана) чадавхийг нэмэгдүүлэх болно. Иргэний нийгмийн байгууллагын мэдээлэл боловсруулах, дүгнэлт хийх, мэдээллийг түгээх чадавхи мөн нэмэгдэнэ.

НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын харьяа **ҮН** -ын хяналт, үнэлгээний баг нь НҮБХТХ-ний хяналт, үнэлгээний төлөвлөгөөний дагуу ерөнхий гүйцэтгэлийг хангах үүргийг хүлээнэ. Ингэхдээ багаар ажиллаж, зохицсон хандлагыг өхиүлэн дэмжинэ. Хяналт, Үнэлгээний багийн ахлагч нь үндэсний тэргүүлэх чиглэлийн Хяналт, Үнэлгээний хурлаар НҮБ-ыг төлөөлнө.

Хяналт, үнэлгээний баг нь НҮБХТХ-ний ажлын хэсгүүд болон хамтарсан хөтөлбөрийн багуудад шалгуур үзүүлэлтийг дахин сайжруулах, с уурь мэдээлэл цуглуулах, хяналтын сайн механизмыг тогтоох, хамтарсан мэдээлэл цуглуулх үнэлгээ, дүгнэлт хийх зэрэг ажилд дэмжлэг үзүүлнэ. [DevInfo](#) нь мэдээллийн удирдлагын ерөнхий системээр ашиглагдана.

НҮБХТХ-ний үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулах зорилтуудын явцыг жил бүр хянаана. НҮБХТХ-ний хяналт, шинжилгээний жилийн тайлангийн хугацааг Үндэсний хөгжлийн цогц бодлогын тайлангийн хугацаатай тааруулж хуваарийг гаргаж болно. **ҮБ** ХТХ-ний ажлын хэсгүүд НҮБ-ын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй **хөтөл**, хөтөлбөрүүдийн явцын тайланг нэгтгэн сайн туршлага, сургамжийг багтаасан товч нэгдсэн тайлан бэлтгэнэ. Тайланд орсон ололтууд болон зөвлөмжийг Суурин зохицуулагчийн жилийн төлөвлөгөө болон жилийн тайланд тусгаж, үндэсний хэмжээнд хийгдэх хяналтын системд мэдээлэл болгож өгнө. НҮБ-ын ХТХ-ний жил тутмын хяналт, шинжилгээний үйл явцад Засгийн газар болоод бусад хэрэгжүүлэгч байгууллагуудын оролцоог хангах нь нэн чухал юм.

НҮБ-ын байгууллагууд болон хэрэгжүүлэгч байгууллагуудтэй хамтран хийсэн үнэлгээ, судалгаа, жилийн тайлан зэрэгт суурилан **ҮН** ХТХ-ний дунд хугацааны үнэлгээг зохион байгуулж болно. Уг үнэлгээний үр дүнд НҮБХТХ-нээс гарч байгаа үр дүн Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтуудад хэрхэн хувь нэмрээ оруулж байгааг үнэлж болох юм. 2012 -2016 оны НҮБХТХ –ний төгсгөлд эцсийн шатны үнэлгээ хийгдэх бөгөөд төгсгөлийн тайлан гарна. Энэ тайлангаас дараагийн шатны НҮБХТХ тодорхойлогдоно.

Үр дүнгийн хүснэгт

Эдийн засгийн тогтвортой хөгжил

Стратегийн тэргүүлэх зорилт 1 : Эдийн засгийн хөгжилд оролцоо, тэгш байдлыг хангаснаар ядуурлыг бууруулахад нөлөөлөх				
Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл:	Шалгуур үзүүлэлт:	Суурь үзүүлэлт:	Зорилтот үзүүлэлт:	Мэдээллийн эх сурвалж:
Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ) ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: Хөгжлийн асуудалд хамааралтай МХЗ-уудыг хэрэгжүүлнэ; Бүлэг 4.1 Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах; 4.7 Шинжлэх ухаан, технологи; 5.2.1.4 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл	Ядуурлын түвшин	Ядуурлын түвшин 38.7% (Үндэсний түвшинд) 30.6% (Хот) 49.6% (Хөдөө)	Ядуурлын үндэсний түвшин 18% хүрч буурна (МХЗ)	ҮСХ-ны жилийн эмхэтгэлүүд
Мянганы хөгжлийн зорилт 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл		Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 4%	ХХААХҮ-н салбарын тайлан

Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБХХ	981,850	1,500,000
ОУХБ	170,000	250,000
НҮБ ХХААБ	2,000,000	3,000,000
НҮБҮХБ	-	230,000
НҮБ-Хабитат	50,000	100,000
НҮБХС	130,000	520,000
НҮБ БСШУБ	50,000	100,000
НИЙТ	3,381,850	5,700,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам. доллар)	
								Боломжит	Дайчлах
ҮР ДҮН 1. Ядуу болон эмзэг бүлгийн хүн амын амьжиргааны нөхцөл сайжирсан байна	Ажиллах хүчний оролцооны түвшин	ҮСХ-ны 2009 оны эмхтгэлд ядуурал үндэсний түвшинд 38.7%, хотод 30.6%, хөдөөд 49.6% байна.	Ажиллах хүчний оролцооны түвшин	ҮСХ-ны жилийн эмхтгэлүүд	- Уур амьсгалын хүчин зүйлүүд: цаг уурын хүндрэл бэрхшээл гарч удаан үргэлжилснээс шалтгаалж зорилтот олон нийтэд хүрч ажиллахад саад тулгарах - Улс төрийн сонгуулиас шалтгаалан ажил хариуцсан хүмүүс солигдох		ОУХБ	100,000	-
	(Үндэсний)	Төсөлд хамрагдах газруудын суурь үзүүлэлтийг тооцсон байх	70% хүрнэ (МХЗ)	Зорилтот газруудын судалгаа			НҮБ ХХААБ	1,800,000	2,700,000
							НҮБҮХБ	-	100,000
							НҮБ-Хабитат	50,000	100,000
	Амьжиргаанд нь эерэг өөрчлөлт гарсан хүмүүсийн % (төсөлд хамрагдсан газраар)	Төсөлд хамрагдсан хүмүүсийн 15 хувийн амьжиргаа сайжирсан байна.					НҮБ ХС	110,000	440,000
							НҮБ БШУСБ	50,000	100,000
Зорилт 1.1 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн болоод бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлэх	Ур чадварын сургалтад хамрагдсан хүмүүсийн ажил эрхэлж байгаа хувь	Ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт зохицохгүй байгаа	Мэргэжлийн болоод бизнес эрхлэх ур чадварын сургалтад хамрагдсан хүмүүсийн 25% нь ажилд орсон байна.	Үнэлгээний тайлан	Уур амьсгалын хүчин зүйлүүд: цаг уурын хүндрэл бэрхшээл гарч удаан үргэлжилснээс шалтгаалж зорилтот олон нийтэд хүрч ажиллахад саад тулгарах	ОУХБ (тэргүүлнэ), НХХЯ, ХХААХҮЯ, МБА, ХХААБ, НҮБОУХБ	ОУХБ	50,000	100,000
		Суурь мэдээлэл тодорхойгүй	Төслийн тайлангууд	НҮБ ХХААБ			200,000	300,000	
							НҮБ ҮХБ	-	30,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам. доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 1.2 Шинээр бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Шинээр бий болсон бичил, жижиг, дунд үйлдвэрийн тоо	Төсөлд хамрагдах газруудад суурь судалгаа хийсэн байх	Бичил, жижиг, дунд үйлдвэрийн тоо	Зорилтот газруудад хийсэн судалгаанууд	ЖДҮ-ийн бүтээгдэхүүн нь их хэмжээгээр орж ирэх хямд төсөр импортын бараатай өрсөлдөх боломж муу	ҮОУХБ-НХХЯ НҮБ-Хабитат УБ хотын захиргаа НҮБ-ын ХХААБ ХХААХҮЯ-НҮБ-ын ҮХБ-ГХХЯ-НҮБХС	ОУХБ	50,000	-
	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Төсөлд хамрагдах газруудад суурь тооцоо хийсэн байх	Төсөлд хамрагдсан өрхүүдийн ажил эрхэлж байгаа хүмүүсийн тоо	ISO/IEC-ийн тайлангууд				НҮБ-Хабитат	100,000
	Төсөлд хамрагдсан хүмүүсийн орлогод гарсан өөрчлөлт, %	Төсөлд хамрагдах газруудад суурь тооцоо хийсэн байх	Төсөлд хамрагдагсад ын орлого наад зах нь 20% -иар нэмэгдсэн байх					НҮБ ХХААБ	500,000
	ISO/IEC 17000 сатндарттай болсон байх	Суурь үзүүлэлт тодорхойгүй	Нэвтрүүлсэн ISO.IEC 17000 стандартын тоо					НҮБХС	440,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам. доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 1.3: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчдийн бүтээмж, зах зээлийн ур чадвар сайжирсан байх	Шинэ технологи, мэдлэгийг ашиглаж байгаа хүнсний үйлдвэрлэгчдийн хувь, %	Сүү сүүн бүтээгдэхүүний дөнгөж 2.2%-г үйлдвэрийн аргаар боловсруулж байна	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү болон махан бүтээгдэхүүний хэмжээ нийт сүүн бүтээгдэхүүний 20% болон махан бүтээгдэхүүний 30 %-д хүрсэн байх	ХХААХҮЯ-ны салбарын тайлан	Зах зээлд өрсөлдөх чадавхи сул, Эдийн засгийн тогтворгүй байдал	НҮБ-ын ХХААБ ХХААХҮЯ НҮБ-ын ОУХБ-ГХХЯ	НҮБ ХХААБ	500,000	500,000
		Хот, хөдөөгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний түвшин	Нийт мах, махан бүтээгдэхүүний 6.4% нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан байна				НҮБ ҮХБ	-	70,000
		Хотын хүн амын сүүний хэрэглээ хөдөөгийнхөөс 3.9 дахин бага байна							

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам. доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 1.4 Эмзэг бүлгийн хүнсний баталгаат байдлыг сайжруулах	Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдэх	Төсөл хэрэгжүүлж байгаа газруудад суурь тооцоо хийх	25% өсөлт	Төслийн үнэлгээний тайлан	Хүнсний үнийн өсөлт илүү олон өрхийн хувьд хүнсний аюулгүй байдал алдагдах байдалд хүргэж болзошгүй	ХХААБ-ХХААХҮЯ	НҮБХХААБ	600,000	1,400,000
	Төсөлд хамрагдсан газруудын хүнсний баталгаат байдал алдагсан айл өрхийн тоо, %	Төсөл хэрэгжүүлж байгаа газруудад суурь судалгаа хийх	Өрхийн орлогоосоо хүнсэндээ зарцуулж байгаа зардал наад зах нь 20%-р буурсан байх	Тодорхойлох					
Үр дүн 2: Ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, стратегийг боловсруулсан байх	Ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээнүүд бүхий Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр (ЯБҮХ) боловсруулах	Байхгүй	Тийм	ҮСХ-ны ядуурлын талаарх мэдээлэл	Төр, засгийн сангууд ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд шууд чиглэхгүй байх	НҮБ-ын ХХ (тэргүүлнэ) ХХААБ НҮБАҮХБ ОУХБ НҮБ-ын ХС	НҮБХХ (тэргүүлнэ)	2,000,000	1, 500, 000
							НҮБХС	20,000	80,000
							ОУХБ	70,000	50,000
							НҮБ ХХААБ	200,000	300,000
	ЯБҮХ-тэй уялдсан ядуурлыг бууруулахад чиглэсэн салбарын бодлогуудын тоо хэмжээ	Суурь үзүүлэлт тодорхойгүй	ЯБҮХ-тэй уялдсан ядуурлыг бууруулахад чиглэсэн салбарын бодлогуудын тоо хэмжээ	Төслийн тайлангууд			НҮБҮХБ	-	130,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам. доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 2.1 Ядуурлыг бууруулах Үндэсний Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх	Бодлогын баримт бичгүүдийн төслийн тоо	Байхгүй	Тийм	-Бодлогын баримт бичгийн төсөл гаргасан эсэх (тийм/үгүй)	Салбарын яамд, төв, орон нутгийн засаг захиргааны хоорондын зохицуулалтын механизм	НҮБ-ын ХХ(тэргүүлнэ) ҮХШХ НҮБ-ын ХСНХХЯ ОУХБ НХХЯ, ХХААХҮЯ	НҮБХХ	981,850	1, 500, 000
	Ядууст чиглэсэн, хүүхдийн эрх ашигт нийцсэн ЯБҮХ боловсруулах, төсвийн төлөвлөлт хийх механизмууд	Суурь үзүүлэлт тодорхойгүй	Ядууст чиглэсэн хүүхдийн эрх ашигт нийцсэн ЯБҮХ боловсруулах, төсвийн төлөвлөлт хийх механизмуудыг бий болгох	-Төслийн тайлангууд			НҮБХС	20,000	80,000
							ОУХБ	70,000	50,000
Зорилт 2.2 Үйлдвэрлэлийн бүтээмж, бүтээгдэхүүний төрөлжилт, брэнд бүтээгдэхүүн болоод экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, стратегийг боловсруулах	Бүтээгдэхүүний төрөлжилт, экспортыг дэмжсэн бодлогын баримт бичгийн төслийг гаргах	Бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан, хэлэлцэж байгаа	Бодлогын баримт бичиг батлагдсан байх	Баримт бичг батлагдсан байх	Салбарын яамд хоорондын зохицуулалтын механизм сул	НҮБ-ын ХХААБ (тэргүүлнэ) ХХААХҮЯ ОУХБ НҮБАҮХБ-ГХХЯ/ ХХААХҮЯ	НҮБХХААБ (тэргүүлнэ)	200,000	300,000
							НҮБҮХБ	-	130,000
	НАССР гэрчилгээ авсан байгууллагын тоо	Байхгүй	НАССР – үйлдвэрлэлд нэвтэрсэн байх	ХХААХҮЯ-ны тайлангууд	Улсын байгууллагуудад мэргэжлийн туршлага хангалтгүй				

Нийгмийн суурь үйлчилгээ, Нийгмийн хамгаалал

Стратегийн тэргүүлэх чиглэл 2 :

Нийгмийн суурь үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, нийгмийн хамгааллын тогтвортой систем бий болгох

Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл:
Үндэсний хөгжлийн стратеги (ҮХС)

- Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх
- Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх
- Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтлах. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна
- Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ.

МХЗ 1, 2, 4, 5, 6

Шалгуур үзүүлэлтүүд:

- Бага боловсролын хамран сургалтын түвшин
- Сайжруулсан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хөдөөгийн хүн амын эзлэх хувь
- Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай хүн амын эзлэх хувь
- 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
- Нялхсын эндэгдлийн түвшин
- Эхийн эндэгдлийн түвшин
- Нийгмийн халамж хамгаалал хүртэгсдийн эзлэх хувь, зорилтот бүлгээр

Суурь үзүүлэлт:

- 91.2%
-49% (08-хөд)
-32% (08-хөд)
- 64% (08-хот)
- 23.7 (09)
- 20.2 (09)
- 81.4 (09)
- 100%
- 100%
-65% (2015-хөд)
-63% (2015-хөд)
83% (2015-хот)
- 21 (2015)
- 15 (2015)
- 50 (2015)
- 35%

Зорилтот үзүүлэлт:

- 100%
-65% (2015-хөд)
-63% (2015-хөд)
83% (2015-хот)
- 21 (2015)
- 15 (2015)
- 50 (2015)
- 35%

Мэдээллийн эх сурвалж:

- Хүүхэд хөгжил судалгаа
- ҮСХ/Үндэсний статистикийн эмхтгэлүүд
- Захиргааны тоон мэдээ, мэдээлэл
- Боловсролын удирдлага, мэдээллийн тогтолцооны тайлан
- Хамтарсан хяналт шинжилгээний хөтөлбөр
- ЭМГ-ЭМЯ-ны жил тутмын эрүүл мэндийн үзүүлэлтүүд

Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ, (ам.доллар)		
	Боломжит	Дайчлах
НҮБХС	2,910,600	11,642,400
ДЭМБ	8,300,000	8,500,000
НҮБХАС	4,470,000	3,200,000
НҮБ-Хабитат	680, 000	2,320,000
НҮБ ХХ	100,000	1,500,000
НҮБ	1,200,000	800,000
БШУСБ Н	185,000	450,000
ОУХБ		
НҮБ-ын ДОХ-ын хөтөлбөр	0	1,000,000
НИЙТ	17, 845, 600	29, 412, 400

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллагууд	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
Үр дүн 3. Эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн боловсролын чанар ба хүртээмж сайжирсан байна	Хүйс, яс үндэс, бүс нутгаар ангилсан бага сургуульд хамрагдалтын түвшин /цэвэр жин/	Бага сургуульд хамрагдалт 94.3% Суурь 89.8% (Үндэсний)	100%	ҮСХ-ийн мэдээ/Захиргааны тоон мэдээ, мэдээлэл	Эрсдлүүд: - Сонгуулийн дараа Засгийн газарт хийгдэх бүтцийн өөрчлөлтүүд, түүнээс үүдэлтэй боловсон хүчний халаа, сэлгээ; - Уур амьсгалын хүчин зүйлс/Байгалийн гамшигт үзэгдэл - Чиглэлийн яамд/үндэсний болоод орон нутгийн засаг захиргааны хоорондын үйл ажиллагааг зохицуулах механизм - Улсын төсвөөс хуваарилсан санхүүжилт хүрэлцдэггүй - Боловсролын удирдлага, мэдээллийн тогтолцоонд үзүүлж буй мэргэжлийн болоод техник арга зүйн дэмжлэг хангалтгүй.	Үндсэн яамд: БСНУЯ, НХХЯ, Хэрэгжүүлэгч агентлагууд - Орон нутгийн засаг захиргаа - НҮБ-ын БШУСБ-ын Үндэсний комисс - Гадны түнш байгууллагууд	НҮБХС НҮБ БШУСБ ОУХБ	969,800	3,879,200
				Боловсролын удирдлага, мэдээллийн тогтолцооны тайлан				1,000,000	500,000
				Хүүхэд хөгжил судалгаа/ Үндэсний статистикийн эмхтгэлүүд				20,000	50,000
Зорилт 3.1 Боловсролын бодлогын хяналт, төлөвлөлт, удирдлагаар хангах үндэсний чадавхи сайжирсан байна.	Боловсролын талаарх шинэчлэн, нэмэлт өөрчлөлт хийж, боловсруулсан үндэсний бодлогын тоо	0	100%	Захиргааны тоон мэдээ, мэдээлэл			НҮБХС	140,000	560,000
	Сургууль, ус ариун цэврийн байгууламжуу-дын талаарх тоон мэдээ, мэдээлэл бүхий Боловсролын удирдлага, мэдээллийн цахим тогтолцоотой болсон байна	Байхгүй	Бий болгох	Боловсролын удирдлага мэдээллийн тогтолцооны тайлан			НҮБ БШУСБ	250,000	300,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрдэл болон таамаглалууд	Түнш хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллагууд	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 3.2. Эмзэг бүлгийнхэн түүний дотор үндэстний цөөнх болоод шилжин суурьшигч хүүхдүүд, хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг үл мэдэгч хүүхдүүдийн сурч боловсрох боломж нэмэгдсэн байна.	- Эмзэг бүлгийнхний сургуульд хамрагдалт, бичиг үсэг тайлагдалтын түвшин	Сургуулийн өмнөх 65.4%	80%	Захиргааны тоон мэдээ, мэдээлэл, сургалтын хөтөлбөр, сургалтын тоон мэдээ, мэдээлэл, үр нөлөөний тайлан	Таамаглалууд: - Засгийн газар хүлээсэн үүргээ сонгуулийн дараа тогтвортой үргэлжлүүлэн гүйцэтгэнэ; - Нэн тэргүүний эмзэг бүлгийнхэнд зориулсан боловсролд Засгийн газраас хангалтай санхүүжилт хуваарилах боломжтой байна.		НҮБХС	416,000	1,664,000
		Анхан шатны 90.4%	100%				ОУХБ	20,000	-
							НҮБ БШУСБ	650,000	100,000
	- Үндэсний цөөнхийн сургуульд хамрагдалтын түвшин (сургуулийн өмнөх, анхан шатны, суурь боловсролд хамрагдах түвшинг нас, хүйс, бүс нутгаар гаргах)	Суурь 91.3% (Зөвхөн Баян-Өлгий) ≈ 40% (хөгжлийн бэрхшээлтэй)	100%						
	- Хөгжлийн бэрхшээлтэй болон шилжин суурьшигч хүүхдүүдийн анхан шатны боловсролд хамрагдалтын түвшин	Байхгүй (шилжин суурьшигч)	3 сургалтын хөтөлбөр 12 сурах бичиг						
	- Үндэсний цөөнх хүүхдүүдэд зориулж боловсруулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материалуудын тоо;	1 сургалтын хөтөлбөр, 1 сурах бичиг							

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл болон таамаглалууд	Түнш хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгууллагууд	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 11.2. Төвлөрлийг үр дүнтэй сааруулахад чиглэсэн бодлогын таатай орчин бүрдэж, орон нутгийн засаг захиргааны үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагааны чадавхи сайжирсан байна.	Орон нутгийн засаг захиргааны үйлчилгээ үзүүлэх чадавхи	Суурь үзүүлэлт тодорхойгүй	Суурь болоод зорилтот үзүүлэлтүүдийг тодорхойлохын тулд орон нутгийн засаг захиргааг чадавхижуулах хэрэгцээг 2011 онд цогцоор нь үнэлнэ.	Орон нутгийн засаглал, орон нутагт үзүүлж буй үйлчилгээний талаарх асуулгын судалгаа	Төсвийн тухай хуульд төсвийн төвлөрлийг сааруулахад чиглэсэн өөрчлөлт хийх.	ЗГХЭГ, чиглэлийн яамд, орон нутгийн засаг захиргаа, УБ хотын захиргаа	НҮБХХ (тэргүүлэх үүрэгтэй)	1,000, 000	2,000, 000
							НҮБ-Хабитат	100, 000	300, 000
							НҮБХС	70, 000	280, 000
Зорилт 11.3. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг	Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	2010: Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн		Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн 2		Авлигатай тэмцэх газар, чиглэлийн яамд, орон нутгийн засаг	НҮБХХ	500, 000	-

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл, таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгуул-лага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
хэрэгжүүлэх чадавхи сайжирсан байна	Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалтуудыг хангасан байна.	хэрэгжилтийн байдалд анх удаа Өөрийн үнэлгээ хийгдэж, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажил, чадавхийн хэрэгцээг тодорхойлсон.		дахь удаагийн Өөрийн үнэлгээ (2016)		захиргаа			
Зорилт 11.4. Үндэсний гол үйл явцууд дахь иргэний нийгмийн оролцоо нэмэгдэж, хөнгөн шуурхай, хариуцлагатай засаглалыг хангах төр иргэний харилцаа бэхэжсэн байна.	Төр-иргэний нийгэм-төрийн байгууллагуудын хооронд санал солилцдог механизм бий болсон байна	Нийгмийн түншлэлийг бэхжүүлэхэд талуудын чадавхийг сайжруулах шаардлагатай	Санал солилцдог механизмтай болсон байна	Нийгмийн түншлэлд хийсэн үнэлгээ	Улс төрийн хүсэл эрмэлзэл	ЗГХЭГ, УИХ, Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ, ажилтан, ажил олгогчдын байгууллага	НҮБХАС	30,000	30,000
			Бодлогын түвшинд нэн ялангуяа хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт нийгмийн түншлэлийг бэхжүүлэх				НҮБХС	30,000	120,000
	Төр, ажилтан, ажил олгогч нарын хоорондын нийгмийн түншлэл						ОУХБ	120,000	-
ҮР ДҮН 12. Хүний эрхийг дэмжиж, хамгаалах үндэсний тогтолцоо сайжирсан байна.	Эрх зүйн үнэ төлбөргүй тусламж авсан ядуу иргэдийн тоо			НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газрын мэдээллийн сан	Томоохон эрсдэл байхгүй	УИХ, ХЭҮК, ХЗДХЯ, ГХЯ, чиглэлийн яамд	НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр	-	150, 000
				Хүний эрхийг хамгаалах талаар тодорхой хугацааны			НҮБХХ	940,000	1,050,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл, таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгуул-лага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
				интервалтайгаар цуглуулсан тоон мэдээ, мэдээлэлд шинжээчдийн хийсэн дүн шинжилгээ.			НҮБХС	130, 000	520, 000
							НҮБХАС	20, 000	20, 000
							НҮББШУСБ	50, 000	50, 000
							НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлыг эрхлэх Дээд комиссарын газар	35, 000	80, 000
							ОУХБ	30, 000	100,000
Зорилт 12.1. Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхи сайжирсан байна.	Гэрээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн Газраас тайлагнасан байдал	Засгийн газрын 362 дугаар тогтоол (2009 оны 12-р сар)	Үндэсний тайлангуудыг цаг тухайд нь нь гаргаж хүргүүлэх.	НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газрын мэдээллийн сан	Томоохон эрсдэл байхгүй	ХЗДХЯ, ХЭҮК, ГХЯ, Чиглэлийн яамд, Иргэний нийгмийн байгууллагууд	НҮБХХ (тэргүүлэх үүрэгтэй)	-	50,000
							НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн хөтөлбөр	-	150,000
							НҮБХХ	190,000	-
							НҮБХС	60,000	240,000
	Төрийн албан хаагчид, хууль эрх зүйн ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр	Хүний эрхийн сургалтыг хэвшүүлээгүй	2016 он гэхэд төрийн албан хаагчид, хууль, эрх зүйн ажилтнуудыг заавал хүний эрхийн сургалтанд хамрагддаг болгох				НҮБХАС	20,000	20,000
							НҮББШУСБ	50,000	50,000
							НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлыг эрхлэх Дээд комиссарын газар	10,000	80,000
							ОУХБ	30, 000	100,000

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл, таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгуул-лага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
Зорилт 12.2. Ядуу болоод бусад гадуурхагдсан бүлгийнхний эрх зүйн чадавхийг сайжруулах замаар хууль хүн бүрт тэгш шударга үйлчлэх нөхцлийг сайжруулсан байна.	Эрх зүйн үнэ төлбөргүй тусламж авсан ядуу иргэдийн тоо	Эрүүгийн хэрэгт өмгөөлөл үзүүлж байна	Эрх зүйн үнэ төлбөргүй тусламжийн хүртээмж, чанарын талаар суурь үзүүлэлт бий болгоно	Ядуу болон гадуурхагдсан иргэдээс авсан судалгаа	Эрх зүйн туслалцааны тухай хууль батлагдсан байна	ХЗДХЯ, ХЭҮК, Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	НҮБХХ (тэргүүлэх үүрэгтэй)/ НҮБ-ын сайн дурынхны хөтөлбөр	750,000	1,000,000
	Орогнол эрэгчдийн зүгээс дүрвэгчийн статусаа тодорхойлуулах үйлчилгээнд хамрагдсан байдал	Янз бүрийн хүчин зүйлийн улмаас орогнол эрэгчид орогнох эрхээ эдэлж чаддаггүй	Бүх орогнол эрэгчид дүрвэгчийн статусаа бүрэн тодорхойлуулах боломжтой болсон байна.	Шүүх, цагдаа, Эрх зүйн туслалцааны төвийн статистик	Томоохон эрсдэл байхгүй	Монгол улс дүрвэгсдийн асуудлаарх олон улсын гэрээ, конвенцид нэгдээгүй тул НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлыг эрхлэх Дээд комиссарын газар болон Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газрын мэдээллийн сан	ХЗДХЯ, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар, ХЭҮК	НҮБХС (хамтран тэргүүлэх үүрэгтэй)	70,000 280,000
	Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй иргэд, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүд, гэрч нарт зориулсан насанд хүрээгүйчүүдийн эрхийг хамгаалах хороодыг 10 аймаг 2 дүүрэгт ажиллуулна.	Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй иргэд, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүд, гэрч нарт зориулсан насанд хүрээгүйчүүдийн эрхийг хамгаалах хороодын тоо	Насанд хүрээгүйчүүдийн эрхийг хамгаалах хороодыг улс даяар нэвтрүүлнэ	Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд хүүхдэд ээлтэй хууль эрх зүйг тусгаж шинэчлэнэ	Эрх зүйн туслалцааны тухай хууль батлагдсан байна	ХЗДХЯ, ХЭҮК, Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	НҮБХХ (тэргүүлэх үүрэгтэй)/ НҮБ-ын сайн дурынхны хөтөлбөр	750,000	1,000,000
							НҮБ-ын Дүрвэгсдийн асуудлыг эрхлэх Дээд комиссарын газар	25,000	-

Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Эрсдэл, таамаглалууд	Түнш, хамтран ажиллагсдын үүрэг	НҮБ-ын байгуул-лага	Шаардлагатай хөрөнгө нөөцийн хэмжээ (ам.доллар)	
								Боломжит	Дайчлах
ҮР ДҮН 13. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж, жендэрийн асуудлыг бодлого, хөтөлбөрт тусгах чадавхи сайжирсан байна.	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх стратеги (Үр дүн, төсвийн хүрээтэй) Жендэрийн асуудлыг тусгасан салбарын бодлогууд	Улсын төсвөөс 2009 онд 29 сая төгрөг, 2010 онд 45 сая төгрөг хуваарилсан	2015 он гэхэд чиглэлийн яамд, засгийн газартай шууд холбоотой ажилладаг, жендэрийн асуудал хариуцсан агентлаг байгуулагдсан байна.	Жилийн төсөв	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль батлагдана Чиглэлийн яамд болоод засгийн газартай шууд холбоотой ажилладаг, жендэрийн асуудал хариуцсан агентлаг байгуулагдана	ЖТБҮХ, Чиглэлийн яамд, орон нутгийн засаг захиргаа	НҮБХАС (тэргүүлэх үүрэгтэй)	230, 000	200, 000
		Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2002-2015	ЖТБҮХ нь чиглэлийн яамд, засгийн газартай шууд холбоотой ажилладаггүй	2016 он гэхэд салбарын бодлогуудад жендэрийн асуудлыг тусгасан байна.			НҮБХС	20, 000	80, 000
							ОУХБ	30,000	50,000

Хавсралт А: МХЗ-уудын хэрэгжилт

2009 онд хэвлэгдсэн МХЗ-уудын хэрэгжилтийн үндэсний тайланд дурьдсанаар МХЗ-уудын 66 хувь нь өлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Гэхдээ үлдсэн зорилтууд түүний дотор ядуурал, жендерийн эрх тэгш байдал болон үрээлэн буй орчинтой холбогдох МХЗ-уудын хэрэгжилт удаашралтай буюу зарим тохиолдолд ахицгүй байна.

МХЗ-уудын хэрэгжилтийн төвшин харилцан адилгүй, зөрүүтэй байх явдал байсаар байна: ялангуяа ажил эрхлэх боломж, нийгмийн суурьчилгээ, хоол тэжээл ийн хүртээмж ба хүнсний аюулгүй байдлын үзүүлэлт нь хот ба хотын зах, өдөө орон нут агт; эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн хувьд; үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн бусад ядуу болон эмзэг бүлгийн хувьд үндэсний түвшнөөс доогуур байна.

Үндэсний түвшинд сургуульд хамрагдалтыг нэмэгдлэх ба эх, хүүхдийн эндэгдлийг багасгахад дорвитой ахиц гарсан байна. Хоол тэжээлийн архаг дутагдлын тархалт өндөр хэвээр байгаа өгөөд ундны цэвэр усны хүртээмж ба эрүүл ахуйн нөхцөл бүс нутгийн дунджаас хавьгүй доогуур байна. Эдгээр бүх зорилт, тэр ч байтугай үндэсний дунд аж үзүүлэлтээр ахицтай байгаа зорилтуудын хувьд ч, суурь мэдээлэл, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг газар зүйн хамрах хүрээгээр нь задлан ангилахад тэгш бус байдал илт харагдаж байна. Хөдөө орон нутаг болон хотын захын хорооллууд, зарим угсаатны цөөнхийн хувьд боловсрол, хоол тэжээл ба эрүүл мэндийн үзүүлэлтүүд үндэсний дунджаас хавьгүй доогуур байгаа нь тэдэнд чиглэсэн хөрөнгө оруулалт, хөгжлийн чиг хандлага зайлшгүй шаардлагатай байгааг нотлон харуулж байна.



МХЗ 1 – ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ Б УУРУУЛАХ:

Зорилт 1: Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах

Зорилт 2: Хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 гэхэд 6 дахин бууруулах

Зорилт 3: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах

Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн үйлчилгээнд хамруулах

Өнгөрсөн таван жилд Монгол Улсын эдийн засаг тууштай өссөн хэдий ч ядуурал маш бага хэмжээгээр буурсан байна. Одоогийн тооцоогоор үндэсний хэмжээнд ядуурлын түвшнээс

доогуур амьдарч байгаа хүмүүсийн эзлэх хувь 27-35 хувийн хооронд хэлбэлзэж байна. Энэ тоо баримтаас харахад тус улсад ойрын хугацаанд гарсан эдийн засгийн ядуурлыг бууруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байна. Үүний зэрэгцээ тэгш бус байдлын түвшин өссөн нь Жини коэффициент 2003 онд 0.33 байсан бол 2008 онд 0.36 болон нэмэгдсэнээр харагдаж байна.

Ядуусын олонхи нь ажил эрхэлдэг боловч цалин багатай бод ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байна: ядуу өрхийн 73.6% -д өрхийн тэргүүн нь ажил эрхэлж байна.¹¹ Үүнээс харахад Монголын эдийн засгийн өсөлт ажлын байрыг төдийлөн нэмэгдүүлж чадаагүй бөгөөд ядуучуудын эрх ашгийн төлөө, бүх нийтийг хамарсан эдийн засгийн өсөлтийн бодлого, нийгмийн хамгааллын тогтолцоо сул байна.

Хүүхдийн ядуурал ч буурахгүй байна. ҮБ -ын Хүүхдийн сангийн тооцоолсноор Монголын нийт хүүхдийн бараг 43% нь ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байна. Ядуу өрхүүдийн тоо нэмэгдэж, гэр бүлээс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаагаас хүүхдүүд гэр бүлийн хүчирхийлэл, зүй бус харьцаа, үл хайхрах байдал, мөлжлөг зэрэг нийгмийн эрсдэлд өртөж байна. Өнгөрсөн таван жилд ядуурлын хувь дөнгөж 1.6%-иар буурсан нь МХЗ-ын зорилтоос хавьгүй доогуур байгаа бөгөөд 2015 он болоход тав хүрэхгүй жил үлдээд байна.

Монголд өнөөдөр амьдралын боломж муутай эмэгтэйд, хүүхдүүд, хүрэлцээгүй тэтгэврээр амь зогоох гэж зүтгэж буй тэтгэврийн хөгшчүүд, ажилгүйчүүд болон бага цалинтай ажилчид, шилжин суурьшигчид болон өгжлийн бэрхшээлтэй иргэд ядууралд өртөж байна. Тэдэнд ядуурлаас гарахад нь тухайн болох нийгмийн хамгааллын зохистой механизм дутагдаж байна. Засгийн газраас судалгаа тооцоогүйгээр зардлыг өсгөж, түүний дотор цалинг нэмэгдүүлж байгаа нь инфляцийг хөөрөгдөж, ядуусын амьжиргааг улам дордуулж болзошгүй гэсэн санаа зовнил нэмэгдэж байна.

Түргэцтэй явагдаж буй хотжилтын үйл явцтай холбоотойгоор хот ба хөдөөгийн ядуурлын түвшний ялгаа нэмэгдсээр байна. Хөдөөгийн ядуусын хувьдөвлийн хүнд хэцүү нөхцлөөс дайжих, илүү таатай ажил эрхлэх боломж хайх, нийгмийн суурь үйлчилгээг хүртэх зорилгоор хот суурин газрууд руу шилжин суурьших нь нэмэгдэж байна. Өнөөдөр нийт 2.7 сая хүн амын 38% нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа бөгөөд үүнээс 600,000 нь хотын захын гэр хороололд оршин сууж байна. Үүний 22 хувийг ядуус эзэлж байна.

Гэр хорооллын оршин суугчдад ажил эрхлэх боломж хязгаарлагдмал, үндсийн чанартай үйлчилгээний хүртээмж хангалтгүй, боловсролын үйлчилгээний чанар муу бөгөөд дутагдалтай, ус хангамж, эрүүл ахуйн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна. Гэр хороолол дахь ядуурал нь нийгмийн хурцадмал байдал, жендерт суурилсан хүчирхийллийг нэмэгдүүлж байна. Иргэний бүртгэлд тавигддаг шаардлагын улмаас хотын захын хороололд хөдөөгөөс шилжин суурьшигчид эхэн үедээ газар авах, хүүхдүүдээ сургуульд хамруулах, хууль эрх зүйн болон төрийн бусад үйлчилгээг авахад хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна.

Тус орны ядуу иргэдийн 73% нь хот суурин газруудад бага цалинтай ажил эрхлэх буюу хөдөө орон нутагт мал маллаж, газар тариалан эрхэлж байна. Хөдөөгөөс хот руу чиглэсэн

¹¹ Үндэсний статистикийн газар, 2007-2008 оны өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа, Гол үр дүнгүүдийн хүснэгт, (Улаанбаатар, 2009 он), Хүснэгт 18

шилжилт, суурьшил нь хотын ядуурлыг нэмэгдүүлж байна. Эмэгтэйчүүдийн хувьд ажил эрхлэх боломж бага бөгөөд ажил олж чадсан нэг нь эрэгтэйчүүдээс бага цалин авч байна. Залуусын ажилгүйдэл түгээмэл бөгөөд их дээд сургууль төгсөгчид ажил олохын тулд 1.6-3 жил зарцуулж байна.

Монгол оронд үнсний аюулгүй байдал ядууралтай нягт холбоотой байна. Хот ба хөдөөгийн хүн амын хоорондох хүнсний хэрэглээний ялгаа арилахгүй байна. НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагын судалгаагаар өрхүүд орлогынхоо 80%-ийг хоол үнсэнд зарцуулж байна.

Хүүхдүүдийн 21 гаруй хувь нь хоол тэжээлийн архаг дутагдалтай байгаа бөгөөд хөдөө орон нутагт энэ үзэмж өндөр хувьтай байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд хоол тэжээлийн дутагдал онцгой санаа зовоосон асуудал бөгөөд энэ нь олон аймагт хүүхдийн эндэгдлийн үндсэн шалтгаан болж байна.

Засгийн газраас ядуурлыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, тогтвортой амьжиргааны хөтөлбөр, сангууд түүний дотор Хүний хөгжлийн сангаар дамжуулан 220 тэрбум төгрөгийн шууд ба шууд бус хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Гэхдээ эдгээр санаачлагуудыг нөлөөг дээшлүүлэхийн тулд хөтөлбөрүүдийг илүү оновчтой чиглүүлж тэдгээрийн хяналт, шинжилгээг сайжруулах нь зүйтэй.

Монгол Улс ядуурлыг бууруулах МХЗ 1-ийг хэрэгжүүлэхийн тулд хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай байна. Өнгөрсөн таван жилд ядуурал маш бага хэмжээгээр буурсан нь Мянганы Хөгжлийн энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дорвитой хөрөнгө оруулалт, бодлогын шинэчлэл шаардлагатайг харуулж байна.



МХЗ 2 – БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ:

Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох

МХЗ 2-ын үзүүлэлт ерөнхийдөө эерэг байгаа бөгөөд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 93.5%, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 95%-тай байна. Гэхдээ хөдөө орон нутгийн 7-15 насны хүүхдүүдийн 8% нь сургуульд хамрагдаагүй бөгөөд тэдний 19% нь наймдугаар анги төгсөхөөс өмнө сургууль завсардаж байна.

Монгол Улс сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэхэд бодитой ахиц гаргасан боловч боловсролын чанар анхаарлын төвд байгаа бөгөөд ялангуяа хот ба хөдөөгийн боловсролын чанар ихээхэн ялгаатай байна. Дээд боловсрол зардал багатай, чанар муутай байгаагийн зэрэгцээ, сургууль-төвтэй болон мэргэжлийн бусад сургалт дутагдалтай байгаа нь сургууль төгсөгчдийн мэдлэг чадвар ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ хоорондын үл нийцлийг нэмэгдүүлж байна. Дэлхийн

Банкны 2010 оны тайланд дурьдсанаар нийт их, дээд сургууль өгсөгчдийн дөнгөж 36% нь ажилтай болж байна.¹²

Хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн болон “тудамжны” (хараа хяналтгүй) хүүхдүүдийн хувьд сурч боловсрох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын сүүлийн тооллогоос үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын талаас илүү хувь нь сургуульд огт хамрагдаагүй байна. Монголын баруун бүсийн аймгуудын нэг болох Баян-Өлгий аймагт тус улсын Казах иргэдийн дийлэнх хэсэг оршин суудаг бөгөөд тэнд сургууль завсардалт хамгийн өндөр, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Бичиг үсэг үл мэдэгчдийн эзлэх хувь улсын дунджаар 4,6% байхад тус аймагт 6,7%-тай байна.

Үндэсний цөөнх болох Казах, Духа болон Тува хүүхдүүдийн хос хэлээр боловсрол эзэмших нөхцөл бүрдээгүй байгаа нь чанартай боловсрол эзэмших боломжийг нь хязгаарлаж байна. Казах хүүхдүүдэд бага сургуулийн хичээлийг казах хэл дээр явуулж байгаа боловч сургалтын хөтөлбөр, сурах бичиг монгол хэл дээр байгаа нь тэдний төрөлх хэлээрээ боловсрол эзэмших, суралцах эрхийг хязгаарлаж нөхцөл болж байна. Хөвсгөл аймгийн хойд хэсэгт олноор суурьшсан Тува хүүхдүүд монгол сургуульд суралцаж, боловсролын ямар нэгэн үйлчилгээг төрөлх хэлээрээ авах боломжгүй байна. Зөвхөн Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд Тува бага сургуульд 200 гаруй хүүхэд суралцаж байна. Сургуулийн орчныг ерөнхийд нь авч үзвэл, Улс орны нийтлэг нэлгээнд дурьдсанаар тоглоомын талбай зэрэг “хүүхдэд ээлтэй” орчин дутагдалтай бөгөөд ундны ус, ариун цэврийн байгууламж зэрэг эрүүл ахуйн хангамж, нөхцөл хангалтгүй байна.

Сүүлийн жилүүдэд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт эрчимтэй өссөн боловч боловсролын чанар, тэгш хүртээмжтэй байдал нь тулгамдсан асуудал хэвээр байна. Бага боловсролын стандарт болон малчид болон ядуурхүүдийн хүүхдүүд ихэвчлэн суудаг сургуулийн дотуур байрны нөхцөл муу, өвлийн улиралд амьдрахад тохиромжгүй байгаа зэргийг засан сайжруулахад дорвитой бөгөөд тогтвортой хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Боловсролын хувьд, ялангуяа боловсролын үвшин дээшлэхийн хэрээр түүний чанар, амьдралд нийцтэй байдал хангалтгүй, орон нутгийн түвшинд хариуцлага дутагдсанаас шалтгаалан салбарын хомсхон нөөц үр ашиггүй зарцуулагдаж байна.

¹² Дэлхийн Банк, 2010, Монгол дахь дээд боловсролын тухай бодлогын тайлбар: Дэлхийн эдийн засгийн сорилтыг шийдэх нь, х-5.



МХЗ 3 - ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВИНД ЭМЭГТЭЙЧҮҮД ИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ :

- Зорилт 6: 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах.*
- Зорилт 7: Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендерийн тэгш байдлыг хангах*
- Зорилт 8: Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх*

Монгол улс дахь жендерийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдлын үзүүлэлтүүдээс харахад улс өр дэх эмэгтэйчүүдийн оролцоо хэт хомс, шийдвэр гаргах түвшин дэх тэдний төлөөлөл тун хангалтгүй байна. Өнөөгийн байдлаар парламентын 76 гишүүний ердөө гурав нь, Засгийн газрын танхимын гишүүдийн нэг нь л эмэгтэй байна. Монгол улс цалин хөлс олгохдоо жендерийн тэгш байдлыг хангах талаар хоцорч, эмэгтэйчүүд ихэвчлэн боловсрол, эрүүл мэнд, жижиглэн худалдаа зэрэг цалин багатай ажил эрхэлж байна. Жендерт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүд, хүүхдүүдэд сөргөөр нөлөөлж буй ноцтой асуудал хэвээр байна.



МХЗ 4 – ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ:

- Зорилт 9: Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах*

1000 амьд төрөлтөд ногдох нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улс дорвитой ахиц гаргаж байна. Одоогийн байдлаар нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 23.7 байна. Хүчин чармайлтаа нэгтгэж, хот хөдөөгийн тэгш бус байдалд илүү анхаарал тавьж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрх тэгш байдлыг хангаснаар энэхүү зорилтыг 2015 он гэхэд хэрэгжүүлэх боломжтой.



МХЗ 5 –ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ:

Зорилт 10: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 гэхэд 4 дахин бууруулах

Эхийн эндэгдлийн хувь 100,000 амьдралт тутам 65 болж 30% -иар буурсан боловч Монголын хүн ам цөөн учир жил тутмын статистик ихээхэн өөрчлөлттэй байдаг. Гэвч зарим аймагт эхийн эндэгдэл 100,000 амьдралт тутамд 200 хүрч байгаа нь эхийн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй байгааг илтгэж байна. Энэхүү тэгш бус байдлыг арилгахын тулд орон нутгийн онцлог, төвөөс алслагдсан байдал, тэгш хүртээмжтэй байдал зэргийг харгалзан өсвийг хуваарилж, стратегийг тохируулан боловсруулах шаардлагатай байна.

Улс орны нийтлэгүнэлгээнд тодорхойлсон эрүүл мэндийн салбарт тулгарч буй гол сорилтууд нь:

1. Эрүүл мэндийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж нь хот ба хөдөө, чинээлэг ба ядуу хүн амын хувьд зөрүү ялгаатай.
2. Эрүүл мэндийн салбарт боловсон хүчин дутмаг бөгөөд санхүүжилт хангалтгүй.
3. Хоол тэжээл, эх, нялхас, хүүхдийн болон өсвөр насныхны эрүүл мэндийн бодлого ба чадавхи дутагдалтай; хоол тэжээлийн асуудлаар хүлээх хариуцлагын зохицуулалт тодорхойгүй; жендерт суурилсан хүчирхийллийн талаар авч буй арга хэмжээ зохицуулалтгүй; ХДХВ/ДОХ, БЗДХ болон сүрьеэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт сул, хуваарилалт тэгш бус.
4. Халдварт бус өвчний менежментийн цогц стратеги, тодорхой алсын хараа дутмаг.
5. Монгол улс байгалийн гамшиг болон халдварын тархалтын онцгой үрхцөл байдалд ажиллах бэлтгэл хангалтгүй байна.



МХЗ 6 – БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС /ХДХВ/, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ (ДОХ), СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 11: 2015 он гэхэд ХДХВ/ДОХ-ын халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

Зорилт 12: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах

Зорилт 13: Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах

Монгол Улс ХДХВ-ын тархалт багатай орон бөгөөд 2009 оны эцсээр насанд хүрэг сдийн 0.02 хүрэхгүй хувь нь энэ вирусын халдвартай гэсэн тооцоо байна. Гэвч сүүлийн таван жилийн хугацаанд ХДХВ-ын бүртгэгдсэн тохиолдлын тоо огцом буюу 80 хувьсчээ. Энэ халдвар бэлгийн замаар голлон тархаж байгаа бөгөөд эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд (ЭБЭ) ХДХВ-ын халдварт өртөх хамгийн өндөр эрсдэлт бүлэг болоод байна (ойролцоогоор нийт тохиолдлын 80 хувь нь ЭБЭ).

Монгол Улсад БЗДХ-ын тархалт өндөр байгаа нь хүмүүс эрсдэл өндөртэй бэлгийн зан үйлтэй байгаагийн илрэл бөгөөд үүнийг дотоодод болон хил залгаа орнуудын хооронд шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаагаар холбон тайлбарлаж болно. Одоогоор улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн халдварт өвчний 43%-ийг БЗДХ эзэлж байгаа нь тус орныг ойрын ирээдүйд ХДХВ/ДОХ-ын тархалтад эмзэг өртөмхий болгож байна.

ХДХВ-ын халдвартай эмэгтэйчүүдийн тал хувь нь биеэ үнэлэгч эмэгтэйчүүд бөгөөд нийт тохиолдлын 10 хувийг эзэлж байна. Биеэ үнэлэх нь хууль бус тул энэ бүлгийнхнийг илрүүлэн, хүрч ажиллахад хүндрэлтэй байдаг. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үр дүнтэй үйлчилгээг хослуулах замаар ХДХВ/ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх ажлыг ялангуяа залуучууд болон өсөр насныхны дунд хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Сүрьеэ өвчний хувьд Монгол улс Ази, номхон далайн бүсэд хамгийн өндөр өвчлөлтэй орны тоонд ордог. Ядуу хүн амд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх болон олон эмэнд дасалтай сүрьеэгийн асуудал нь бэрхшээлтэй хэвээр байна.

Хорт хавдар, зүрх судасны өвчин, осол гэмтэл зэрэг халдварт бус өвчнүүд Монголын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна. Эрүүл мэндийн байгууллагуудад, ялангуяа хөдөө орон нутагт чадварлаг боловсон хүчин, шаардлагатай тоног төхөөрөмж, эм хэрэгсэл хүрэлцээгүй байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарын санхүүжилт хангалтгүй байна.



МХЗ 7 –БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ:

- Зорилт 14:** *Тогтвортой хөгжлийн зарчмыг үндэсний хөгжлийн бодлого хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх*
- Зорилт 15:** *Гол, горхины усны эхийг хамгаалж, өжөн сэргээх замаар ширгэлтийг багасгах*
- Зорилт 16:** *Баталгаат ундны усны хангамжийг сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах*
- Зорилт 17:** *Хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах*

Байгаль орчны доройтол нь Монгол улсад тулгамдсан асуудал болоод байгаа бөгөөд эдийн засаг, соёлын хувьд ноцтойр дагавар учруулахуйц асуудлуудын нэг юм. Өнөөдөр тус орны орчны экосистем зайлшгүй аюулд өртөж байгаа бөгөөд ялангуяа бэлчээрийн газар нутаг (70% нь ямар нэг хэмжээгээр доройтсон), ой, усны нөөц, биол огийн олон янз байдлын доройтол, хот суурингийн агаарын бохирдлын асуудлууд хурцаар тавигдаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн урт хугацааны үр дагавар нь чухлаар авч үзэх асуудал болоод байна. 2009-2010 оны өвлийн зуд Монгол орон цаг уурын эрс тэс үзэгдлүүд болон байгалийн гамшигт эмзэг өртөмхий болохыг тодорхой харуулсан билээ. Уур амьсгалын өөрчлөлтийн урт хугацаанд аажим илрэх дагаврууд нь: экологийн үс бүслүүр болон ургамлын бүрхэвч шилжиж солигдох; говь нэвчлэх бүс хойш өргөжих; хур туна дасны горим өөрчлөгдөх; усны хомсдол үүсэх, бэлчээрийн газар доройтож ургамлын гарц буурах; үргэлжилсэн халуун өдрүүд ба хүйтэн улирал уртсах шинжээр илэрнэ. “Ногоон” эдийн засгийн хөгжлийн зарчимд шилжих болон “ногоон” ажлын байрыг бий болгох явц харьцангуй удаашралтай байгаа бөгөөд эдгээр санаачилгыг хурдацтай нэвтрүүлэхэд манлайлал шаардлагатай байна.

Хөдөө орон нутаг болон хотын захын хорооллуудад ус хангамж ба ариун цэврийн байгууламжийн хүртээмж хангалтгүй байгаа нь хүн амын эмзэг давхаргын аюулгүй байдалд шууд, ноцтой аюул учруулж байна. Усгүй нь гол төлөв эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн ажил байдаг бөгөөд ус түгээх цэг, худаг нь хол зайтай байрлах тохиолдол түгээмэл байна. Хөдөө орон нутгийн болон гэр хорооллын хүн амын маш бага хувь нь сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж байна. ДЭМБ ба ҮБ -ын Хүүхдийн сангаас хамтран хэрэгжүүлсэн хяналт мониторингийн хөтөлбөрийн судалгаагаар үндэсний хэмжээнд ундны ус хангамж сайжирсан боловч хөдөөгийн хүн амын тал хүрэхгүй хувь нь баталгаат эх үүсвэрээс ундны ус авах боломжтой, гуравны нэгээс бага хувь нь ариун цэврийн байгууламжид хамрагдсан байгаа ба энэ нь газарзүйн бүс нутаг бүрт харилцан адилгүй байна. Суулгалт өвчин хүүхдийн өвчлөл болон нас баралтын нийтлэг шалтгаан болж байна. Ус, ариун цэврийн байгууламжийг болон оршин суугчдад эзэмшүүлэх, эрүүл ахуйн дадал зуршлыг өөрчлөх нь томоохон сорилт болж байна.

Монголд усны нөөц хомсдож байгаа бөгөөд энэ нь аж үйлдвэржилт болон усны хэрэглээ өссөнөөс түлхүү шалтгаалж байна. Олон аймаг, сумдад ундны усны чанар туйлын хангалтгүй байдаг. Үндэсний хэмжээнд ус ба ариун цэврийн байгууламийн хэргэмжийг сайжруулахад уламжлалт дадал зуршлыг өөрчлөх, засгийн газрын байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, салбарын зохицуулалт, төлөвлөлтийг сайжруулах болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлуудыг авч үзэх шаардлагатай.



МХЗ 8 – ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ:

- Зорилт 18:** Худалдааны болон салбарын тогтолцоог хөгжүүлэх замаар МХЗ-уудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх
- Зорилт 19:** Далайд гарцгүй Монгол улсын онцгой хэрэгцээ шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх
- Зорилт 20:** Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийг стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол улсын хувь, эдийн засагт үндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх
- Зорилт 21:** Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах

Монгол Улс далайд гарцгүй орон учир энэхүү Мянганы хөгжлийн зорилт нэн чухал ач холбогдолтой. Шилжилтийн үе эхэлсэн 1990 оноос хойш тус орон төвийг сахих, дэлхийн бүх оронтой найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэх чиг шугам бүхий гадаад бодлогыг үргэлжлүүлэн баримталж байна. Хэдийгээр дэлхийн хоёр том түрэн болох ОХУ, БНХАУ-ын дунд оршдог боловч Монгол улс “Туравдагч өршийн бодлого”-роо АНУ, Япон, Солонгос, АСЕАН-ы гишүүн орнууд, Европын холбоо зэрэг орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж байгаа бөгөөд тэдний ихэнх нь өнгөрсөн хорин жилд томоохон хандивлагчийн үүрэг гүйцэтгэж ирсэн.

Уул уурхайн салбарын цаашдын үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хирээр Монгол улсын ДНБ болон санхүүгийн тогтвортой байдал бэхжиж улмаар төлөвших хандлагатай байгаа тул хөгжлийн албан ёсны тусламж буурах төлөвтэй байна. Монгол улс одоогоор дэлхийн 110 гаруй улстай худалдаа хийж байна. Худалдаа өлөх бодлогын үр дүнд 2008 оны гадаад худалдааны нийт эргэлт 1996, 2000, 2004 оныхоос гурваас зургаа дахин нэмэгдсэн байна.

Түүнчлэн Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-тай Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх хэлэлцээрийг 2007, 2008 онд тус тус байгуулсан бөгөөд Монгол улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хэлэлцээр хийгдэж байна.



МОНГОЛ УЛСААС ТУСГАЙЛАН БАТАЛСАН МХЗ 9- ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛЖ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

- Зорилт 22:** *Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох,*
- Зорилт 23:** *Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх,*
- Зорилт 24:** *Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх.*

Монгол Улс ардчилсан засаглал, хүний эрхийн талаар Мянганы хөгжлийн бие даасан ес дэх зорилтыг санаачлан боловсруулсан билээ. Хөгжиж дэвшин, ядуурлыг бууруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд сайн засаглал чухал ач холбогдолтой болохыг Мянганы тунхаглалд онцлон тэмдэглэсэн байдаг. Монгол Улс 1992 онд шинэ үндсэн хуулиа баталснаас хойш парламентын тав, ерөнхийлөгчийн таван сонгуулийг явуулж, ардчиллыг бэхжүүлэхийн төлөө тууштай замнаж ирсэн билээ. Гэвч УИХ-ын 2008 оны сонгууль будилаантай болсон гэх шалтгаанаас үүдэлтэй олон нийтийн жагсаалын үеэр таван хүн амиа алдаж, тус улсад онц байдал зарласан нь Монгол улсад ардчилал хэврэг байгааг илтгэв. Мөн түүнчлэн ядуурал, хотын агаарын бохирдол, зам тээвэр, үржлэн буй орчны доройтол, газар, орон сууцны асуудлууд, нийгмийн суурьчилчилгээг хүргэхэд дорвитой анхаарал хандуулахгүй байгаад иргэд сэтгэл дундуур байна.

Орон нутгийн засаг захиргааны хэтөвлөрөл ч дээрх асуудлуудад нэрмээс болж байна. 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдсанаас хойш орон нутгийн засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын эрх мэдэл эрс хумигдсан. 1990-ээд оноос хойш хотжилт эрчимтэй явагдаж, орчин үеийн хотын удирдлага, засаглалын шаардлагад нийцүүлэн орон нутгийн засаг захиргааны хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. УИХ төсвийн удирдлагын шинэ үйл явц түүний дотор төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүгийн төвлөрлийг сааруулах асуудлыг нарийвчлан тусгасан Нэгдсэн төсвийн тухай хуулийг шинээр батлах гэж байна.

Авлига бүх түвшинд байгаа нь хүлээн зөвшөөрөгдөж, улам бүр газар авч байгаад санаа зовниж буйгаа хандивлагчид, хувийн хэвшлийнхэн илэрхийлсээр байгаа хэдий ч авлигатай тэмцэх хүчин чармайлтууд бодитой үр дүнд хүрэхгүй л байна. Транспарэнси Интернэйшнл

байгууллагаас 2010 онд гаргасан авлигын төсөөллийн индексээр Монгол Улс дэлхийн 189 орноос 116-д оржээ.

2010 оны байдлаар Монгол Улс олон улсын эрхийн 30 гаруй гэрээ, конвенци д нэгдээд байна. Хүний эрхийн хамгааллыг сайжруулахын тулд бодлогын хэд хэдэн баримт бичгийг боловсруулж, 2009 оны 12 дугаар сард Засгийн Газар “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай үндэсний илтгэл бэлтгэх тухай журам” -ыг баталж, тухайн конвенцийн хэрэгжилтийг хариуцсан засгийн газрын агентлагуудын хариуцлагын механизмыг тодорхойлон тогтоов.

Иргэний эрхийг ерөнхийд нь сахин хангаж байгаа ч цагдаа болон хүчний байгууллагуудын үйл ажиллагаа, шоронгийн үхцлийн асуудал санаа зовоосон хэвээр байна. Шоронгийн дэд бүтэц, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын чадавхийг бэхжүүлэхэд төрөөс дорвитой хөрөнгө оруулалт хийсний үр дүнд нөхцөл байдал сайжирч байна. 2010 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж цаазын ялд түр хориг тавьсныг олон улсын хамтын нийгэмлэг түүний дотор НҮБ сайшаан хүлээн авлаа.

Хохирогчдын эрхийн хамгаалалт хангаж байгаа бөгөөд ихэнх тохиолдолд гэмт хэрэгтэнд ял оноосон ч гэмт хэргээс учирсан хохирол өхөн төлөгддөггүй. Хөдөлмөр эрхлэлт албан бус шинжтэйгээс гадна хөдөлмөрийн гэрээ тэр бүр хийгдэхгүй байгаагийн улмаас хөдөлмөрийн эрх ноцтой зөрчигдөж байна.

НҮБ-ын хүний эрхийн гэрээний байгууллагууд тухайлбал Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах Үх хэлбэрийг устгах тухай конвенц (2008 оны 42 дугаар хуралдаан) болон Хүүхдийн эрхийн тухай конвенцийн (2010 оны 53 дугаар хуралдаан) хороод конвенцийн хэрэгжилт сул; эмэгтэйчүүд, хүүхдүүдэд тулгарч буй нөхцөл байдал, хууль, тогтоомжуудын үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, үнэлэх хяналтын тогтолцоо байхгүй; үндэсний болон орон нутгийн түвшинд төсвийн хуваарилалт хангалтгүй; конвенцийн хэрэгжилтийн ахиц дэвшлийг үнэлэх шалгуур, хэмжүүр байхгүй байгааг онцолсон байна. 2009 оны 5 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг баталснаас хойш түүний хэрэгжилтэд дорвитой ахиц ажиглагдахгүй байна.

2010 оны Хүний эрхийн төлөв байдлын тогтмол түгээмэл хяналтын үеэр оролцогч орнууд хүний эрхийн асуудлууд түүний дотор ядуурал, ажилгүйдэл, авилгаас үүдэлтэй төрийн үйлчилгээний доройтол, эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагын талаарх хуучинсаг хэвшмэл ойлголт амьтэйд хадгалагдсаар байгаа явдал, охид эмэгтэйчүүдийг худалдаалах, мөлжих явдал газар авч, буруутай этгээдүүд тэр бүр хариуцлага хүлээдэггүй, орон гэргүй иргэд болоод хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоо өсч, үндсэрхэг үзэл гаарч, хүн амын цөөнх түүний дотор гей, лесби, бисекс, транссексуал иргэдийг ялгаварлан гадуурхаж байгаад санаа зовниж буйгаа илэрхийлэв.

Энэ бүс нутагт Монгол руу чиглэсэн орогнол хүсэгчид болон дүрвэгсдийн урсгал нэмэгдэж байна. Монгол Улсын үндсэн хуулиар орогнолын хүрээ заагийг баталгаажуулсан бөгөөд Монгол Улс олон улсын гэрээгээр орогногчдын эрхийг хүндэтгэх, орогнол хүсэгчийг буцаахгүй байх үүрэг хүлээсэн боловч орогнолын үндэсний механизм боловсронгуй болоогүй учир орогнол хүсэгчид болон дүрвэгсдийн хүн ий эрх хязгаарлагдах, өрчигдөх явдал гарч байна.

Иргэний нийгмийн байгууллагууд нь зүл саруул ардчиллын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хэдийгээр зохион байгуулалт, чадавхи, санхүүжилт дутагдалтайн улмаас бэрхшээл, хүндрэлтэй тулгарч байгаа ч цэцэглэн хөгжиж, ерөнхийдөө санал бодлоо чөлөөтэй илэрхийлж чадаж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ч өн бие даах хандлагатай болж, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлж, хүний эрхийн зөрчлүүдийг нийтэд дэлгэхэд чухал үүрэг гүйцэтгэх болжээ.

Эдийн засагсө хийн хэрээр тулгарч буй бэрхшээл бөөцийн тэгш хуваарилалтыг хангаж, нийгмийн суурь үйлчилгээний тэгш бус хангалтыг шийдвэрлэхэд эн тэргүүнд хөрөнгө оруулах явдал юм. Нийгмийн хамгааллын өлжээний тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн хүндрэлтэй үед ч түүнийг алдагдуулалгүй хадгалж, бараа бүтээгдэхүүний ашиг орлогоос хамааралгүй байлган; нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж; тэгш бус байдал түүний дотор нэн хэрэгцээтэй байгаа ундны ус, ариун цэвэр, сургууль эмнэлэг болон замын асуудлыг шийдэхэд хуваарилж буй ДНБ-ий хувь хэмжээг нэмэгдүүлэх явдлыг НҮБ дэмжсээр байх болно. Үүнтэй уялдуулан улсын төсвийг илүү оновчтой хуваарилахын тулд баримтад тулгуурласааөлөвлөлт, төсөвлөлт болон төвлөрлийг сааруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

Товчилсон нэрс

АТГ	Авлигатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГИХАЭГ	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖТБҮХ	Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТБХБЯ	Зам тээвэр барилга хот байгуулалтын яам
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХТХ	НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБХХААБ	НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮББШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НХХЯ	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НҮБСДБ	НҮБ-ын Сайн дурынхны байгууллага
НҮББОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮБҮХБ	НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага
НҮБ-ын ЭЗНЗ	НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл
НҮБЭШЭК	НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУЦЭА	Олон улсын цөмийн энергийн агентлаг
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ҮХШХ	Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо
ХДХВ	Хүний дархлал хомсдлын вирус
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенц
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦХМ	Цэвэр хөгжлийн механизм
ШУА	Шинжлэх ухааны академи
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг эрчим хүчний яам
ЭЯГБХУТОУК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц